

ХЭСЭГ С: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ С8: ХҮН АМ БА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Агуулга

| | |
|---|----------|
| 8. ХҮН АМ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН | 2 |
| 8.1 ТАНИЛЦУУЛГА..... | 2 |
| 8.1.1 Ажиллагсдыг Орон Сууцжуулах Оюу Толгойн хандлага | 3 |
| 8.2 ХАМРАХ ХҮРЭЭ..... | 5 |
| 8.2.1 Орон Зайн Хамрах Хүрээ | 5 |
| 8.2.2 Цаг Хугацааны Хамрах Хүрээ | 6 |
| 8.3 ХҮН АМЫН ШИЛЖИН ИРЭХ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ | 6 |
| 8.3.1 Нөлөөллийн Дүгнэлт | 6 |
| 8.3.2 Бүс Нутагт Болон Бүс Нутаг Хоорондын Хүн Амын Шилжилт Хөдөлгөөн | 7 |
| 8.3.3 Төслийн Нөлөөллийн Бүс рүү Шилжих Хүн Амын Шилжилт Хөдөлгөөн | 13 |
| 8.3.4 Бичил Уурхайн Хяналтгүй Олборлолт | 31 |
| 8.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ХУРААНГУЙ | 33 |

Зургийн жагсаалт

| | |
|--|---|
| Зураг 8.1 Төслийн нөлөөллийн бүсийг харуулав. | 6 |
|--|---|

Хүснэгтийн жагсаалт

| | |
|---|----|
| Хүснэгт 8.1: Ханбогд сумын төвийн хүн ам болон шилжин суурьшсан байдал | 2 |
| Хүснэгт 8.2: Сумын хэмжээний хүн амын өсөлтийн төлөв, 2010 - 2020 он хүртэл | 13 |
| Хүснэгт 8.3 Оюу Толгойн барилгын ажлын үеийн ажиллах хүч (жилийн дундаж үзүүлэлт) болон хүн амын шилжилт хөдөлгөөний шинэчлэгдсэн тооцоолол. | 14 |
| Хүснэгт 8.4: Ханбогд сумруу шилжих хүн амын цэвэр шилжилт (Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг үл тооцно)..... | 16 |
| Хүснэгт 8.5: Нөлөөллийн дүгнэлт: Хүн амын шилжилт хөдөлгөөн | 34 |

8. ХҮН АМ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

8.1 ТАНИЛЦУУЛГА

Оюу Толгой төслийн бүх нэгж Өмнөговь аймгийн захиргааны Ханбогд сумд харъяалагддаг нутаг дэвсгэрт оршдог. Ханбогд сумын төв (сумын төв) нь төсөлтэй хамгийн ойр орших суурин ба уурхайн талбайгаас зүүн хойш 42 км газарт байрлаж, Оюу Толгойтой шороон замаар холбогдоно.¹

Оюу Толгой төслийн уурхайн лицензит талбай (УЛТ), Гашуун Сухайт хүрэх замын зурвас, Гүний Хоолой усны цооногийн талбай болон усны шугам, цахилгаан дамжуулах шугам, зэрэг төслийн бүрэлдэхүүн нэгжүүдийг барих барилгын ажлын үед Монгол болон олон улсын нийт 18,000 (2011 оны байдлаар) ажиллагсад ажиллаж байна. Эдгээр ажилчдыг Ханбогд сумын төв, Оюу Толгойн УЛТ болон Оюу Толгой – Гашуун Сухайтын зам, Гүний Хоолойн ус дамжуулах хоолойн дагуу ажиллагсад зориулсан сууцанд байрлуулдаг.

Төслийн үйл ажиллагаанд ажиллах ажилчид барилгын ажлын төгсгөл төдийгүй уурхайн үйл ажиллагааны бүх шатанд өөрийн гэр бүлийн хамтаар Ханбогд суманд аж төрж, онгоцоор-ирэх-онгоцоор-буцах (ОИОБ) болон автобусаар-ирэх-автобусаар-буцах хувилбарын (АИАБ) тээврийн зохицуулалтаар хангагдана. Төслийн ажилтнуудыг орон сууцжуулах загвар нь төслийн хөдөлмөр эрхлэлт болон үйлчилгээний төв болох утгаараа Ханбогдод төвлөрнө.

Оюу Толгой төслийн орон сууцны анхны загвар нь Өмнийн Говийн бүсийн нутгуудад кэмп болон ажилчдын орон сууцыг тараан байрлуулах төлөвлөгөөтэй байсан. Гэвч ажилчдыг гэр бүлээс нь удаан хугацаагаар тусгаарлаж, улмаар тээвэрлэлт хийх хол зайтай холбоотой үүсч болзошгүй хүндрэлүүдийг харгалзан үзсний үндсэн дээр энэхүү аргыг хэрэглэхээс татгалзсан. Харин өөр нэгэн загвар болох Ханбогд-төвтэй загвар буюу төслийн ажилчдыг уурхай болон сумын төвтэй ойрхон, гэр бүлийн хамт аж төрөх боломж олгохоор төлөвлөсөн (ажиллах хүчний тогтвортой байдлын үндсэн хүчин зүйл). Оюу Толгой төслийн ажиллах хүчний хэрэгцээтэй харьцуулбал сумын төв нь хязгаарлагдмал дэд бүтэцтэй, харьцангуй цөөн хүн амтай, жижиг суурин юм. 2011 онд тус сумын нийт хүн амын тоо 1,455 байсан бол 2010 онд хүн амын тоо 3,522 болж өссөн. Түр оршин суугчдыг оролцуулан (2010 онд хүн амын тооллогын үеэр) сумын төвд байсан болон 183 өдрөөс дээш хугацаагаар оршин суугчдын тоо (ОИОБ ба АИАБ Оюу Толгойн үндсэн болон гэрээт ажилчид дийлэнх нь байсан) 7150-д² хүрч байв.

Өнгөрсөн хэдэн жилд Ханбогд сум руу нүүж ирэх хүн амын шилжилт хөдөлгөөн (УЛТ болон бусад алслагдмал барилгын кэмпд амьдарч буй ажиллагсдыг оруулахгүйгээр сумын төвд оршин суудаг Оюу Толгойн гэрээт ажиллагсад болон ажилтнуудыг оруулан)-ийг дор үзүүлэв.

Хүснэгт 8.1: Ханбогд сумын төвийн хүн ам болон шилжин суурьшсан байдал

| Жил | Сумын төвийн хүн ам | Дотроо нүүн шилжсэн | Гадагшаа нүүн шилжсэн | Цэвэр шилжилт | Шилжилт хөдөлгөөнөөс болж буй хувь өсөх |
|------------------------|---------------------|---------------------|-----------------------|---------------|---|
| 2006 | 2901 | 183 | 33 | 150 | 5.2% |
| 2007 | 2974 | 126 | 72 | 54 | 1.8% |
| 2008 | 3022 | 71 | 68 | 3 | 0.1% |
| 2009 | 3154 | 96 | 50 | 46 | 1.5% |
| 2010 | 3522 | 305 | 49 | 256 | 7.3% |
| 2010 (10-р сар хүртэл) | Ойролцоогоор 3900 | 323 | 86 | 237 | 7.3% (жилд шилжүүлэн тооцсон) |

¹ Оюу Толгой нь Ханбогд сумын төв болон уурхай хоорондын замыг засч сайжруулдаг.

² Үндэсний статистикийн газар. 2010 оны хүн амын тооллого.

Эх үүсвэр: Ханбогд сумын засаг даргын тамгын газар

Монгол улсын өнцөг булан бүрээс Ханбогд сум рүү нүүн ирж буй бүх иргэд сумын захиргаанд бүртгүүлэх ёстой. Энэ нь Монгол улсын нутаг дэвсгэрт түр болон байнгын оршин суух дотоодын болон гадаадын гэрээт ажилчдад хамаатай юм. Үүний үр дүнд тоологдсон сумын төвд амьдарч байгаа бүр оршин суугчдын тоог дээрхи хүснэгтэнд үзүүлсэн.

БОННБУ-ний энэхүү бүлэгт Ханбогд сум руу шилжин ирэх хүн амын хөдөлгөөнтэй холбоотой учирч болзошгүй нөлөөлөл, бүсийн болон сумын хэмжээнд шилжих хөдөлгөөний урьдчилсан таамаглал, хүн амын шилжин суурьших хөдөлгөөнтэй холбоотой нөлөөллийг бууруулах арга хэмжээг тус тус тусгасан болно.

Энэхүү бүлгийн хүрээнд, шилжилт хөдөлгөөн эсвэл хүн амын шилжин ирэх хөдөлгөөн хэмээх нэршил нь Ханбогд суманд шилжин ирсэн хүмүүсийн тоогоор тодорхойлогдож улмаар орон нутгийн хүн ам зүйн бүтцэд өөрчлөлт оруулж, хүлээн авч буй орон нутгийн нийгмийн дэд бүтцэд ачаалал үүсгэхийг хэлнэ.

8.1.1 Ажиллагсдыг Орон Сууцжуулах Оюу Толгойн хандлага

Уул уурхайн урт хугацааны үйл ажиллагаанаас хамаарч ажиллагсдыг амьдрах тав тухтай орчноор хангасанаар Оюу Толгой руу зорчих цагийг хэмнэх учир зохимжтой газрыг сонгох, төслийн нөлөөллийн бүсийн хүн амын шилжилт хөдөлгөөний гол чухал цэг болох Ханбогд сумын тогтвортой орон нутгийг хөгжүүлэх нь маш чухал юм.

Ажиллагсдыг орон сууцаар хангахад дараах хоорондоо уялдаа хамааралтай гурван асуудлыг харгалзан үзэх ёстой. Үүнд:

- Оюу Толгойн үйл ажиллагааны ажилчныг байрны шаардлагууд болон хөнгөн үйлдвэрийн үйлчилгээ болон хангамжийн талбай;
- Ажиллагсдын орон сууцны байршил болон үйлдвэрлэлийн өмч хөрөнгөтэй холбоотой Оюу Толгойн шийдвэр нь сум руу нүүж ирэх шилжилт хөдөлгөөнд нөлөөлнө;
- Бүсийн хөгжлийг дэмжих болон төлөвлөх Оюу Толгойн арга барил нь ажилчдын орон байр, үйлчилгээ, ханган нийлүүлэлт, орон нутгийн хөгжлийн талаарх байршил, бүсийн хөгжлийг дэмжих Оюу Толгойн үүрэг амлалт зэргийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгдсэн байх ёстой.

Оюу Толгой нь үйл ажиллагааны загвар, ажиллагсдыг орон сууцаар хэрхэн хангах, ханган нийлүүлэгчийн байршил зэрэг асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар ахиц гарган ажиллаж байна. ОИОБ шийдэл давамгайлсан хувилбарын оронд ОИОБ болон орон нутагт суурьшуулах (Ханбогд сумын төвд) явдлыг хослуулсан хувилбарыг сонгосон. Энэ нь ажилчдыг уурхайтай өдөр тутам харьцах боломжоор хангана.

Оюу Толгой төсөл нь ажилчдын суурингийн байршлыг эцэслэн сонгох шийдвэр нь хүлээгдэж буй Ханбогд суманд шилжин ирэгсдийн (Оюу Толгой төслийн бүрдүүлсэн боломжуудыг ашиглахаар эрмэлзэж буй) хөдөлгөөний динамикийг өөрчлөх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа.

Байршлыг сонгох явц

Оюу Толгой нь доорхи байгууламжуудын талбайг сонгох ажилд ороод байна:

- Ханбогд сумын орчимд (заавал сумын төвтэй залгаа байх албагүй) төслийн ажилчдыг байрлуулах орон сууц,
- Ханбогд сум дотор боловч боломжтой бол уурхайн талбайтай ойрхон Оюу Толгой төслийн нийлүүлэгч нарын хөнгөн үйлдвэрлэлийн байгууламжууд зэрэг юм.

Орон сууцны хувьд сумын төвийн баруун зүгт залгаа талбайд орон сууцны байршлыг төлөвлөж байгаа бөгөөд энэ газар нь 1) Ханбогд сум Оюу Толгой хоорондын одоо ашиглаж буй замын хойно байрлана 2) одоо байгаа сумын төвтэй ойрхон бөгөөд ингэснээр одоо ашиглагдаж буй буюу ирээдүйд бий болох хотын дэд бүтэц, үйлчилгээ ба байгууламжуудыг ашиглах боломжтой юм 3) хэрэв энэ газарт орон сууцыг байгуулах тохиолдолд одоогийн сумын төв өргөжсөнөөр өрнөх хотжилтын нэгээхэн хэсэг болох боломжтой юм.

Үйлдвэрийн байгууламжуудын тухайд 1) уурхайн талбайн орцтой аль болох ойрхон боловч уурхайн талбайгаас үзэгдэхгүй мөн дуу чимээ сонсогдохгүй газар 2) одоо ашиглагдаж буй (төслийн талбайн

дотор болон гадна) уурхайн байгууламжуудыг (ялангуяа ус болон цахилгааныг) аль болох ашиглах 3) газар ашиглалтын ангиллуудтай (тусгай хамгаалалттай, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий газар) холбоотой гарч болох боломжуудыг ашиглах ба 4) төслийн талбайгаас хойд болон баруун зүгт байрлах (салхин дор) газруудыг сонирхож байна.

Түүнчлэн, орон нутгийн удирдлагатай хийсээр байгаа хэлэлцүүлгийн дүнд Ханбогд сумын төв, Оюу Толгойн ажилчдын суурин болон Оюу Толгой төслийн үйлдвэрлэлийн байгууламжуудыг багтаасан дэд бүсийн хэмжээний хөгжлийн төлөвлөлтийн загварыг зохион байгуулалттайгаар боловсруулж удирдах болно. Энэ нь эдгээрийн эцсийн байршлаас шалтгаалахгүйгээр хөгжлийн ашиг тус Ханбогд сумын хэмжээнд илүү тэнцүүхэн хуваарилагдах боломжийг олгох бөгөөд улмаар шилжин ирэх хөдөлгөөнийг илүү зохицуулалттай болгон Ханбогд сумын төвийн тогтвортой хөгжилд түлхэц үзүүлэх болно.

Ажилчдын орон сууцтай холбоотойгоор Оюу Толгой төслийн баримтлах зарчмууд

Оюу Толгой төсөл нь ажилчдын суурингийн байршлыг эцэслэн сонгох шийдвэр нь хүлээгдэж буй Ханбогд суманд шилжин ирэгсдийн (Оюу Толгой төслийн бүрдүүлсэн боломжуудыг ашиглахаар эрмэлзэж буй) хөдөлгөөний динамикийг өөрчлөх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа. Оюу Толгой ХХК нь өөрийн үйл ажиллагаанд удирдамж өгөх, оролцогч талуудад Оюу Толгой ХХК энэхүү арга хэмжээнүүдийг Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ), Рио Тинтогийн стандарт ба олон улсын практикийн (ОУСК-н Гүйцэтгэлийн Стандарт ба ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага) дагуу хариуцлагатайгаар хэрэгжүүлнэ. Оюу Толгой нь Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан бүсийн хөгжлийг дэмжих энэхүү үүрэг амлалтыг нэр төртэйгээр хүндэтгэн хүлээн авч үзэж байгаа.

Эдгээр зарчим болон амлалт үүрэгт доорхи зүйлс багтана:

- Оюу Толгой төсөл нь аливаа шийдвэр гаргасан тохиолдолд доорхи үүргийг хүлээнэ:
 - Ханбогд суманд зохион байгуулалтгүй, төлөвлөгдөөгүй хүн амын шилжин ирэх хөдөлгөөнийг өөрийн үйл ажиллагаагаар боломжийн хэрээр буруулан зохицуулна,
 - Байгаль орчин болон нийгэмд нөлөөлөх нөлөөллийг бууруулна,
 - Ханбогд сумын дэд бүтцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх,
 - Эмзэг бүлгийнхэнд төлөвлөгөөтэйгээр туслалцаа үзүүлэх,
 - Орон нутгийн оролцогч талууд болон удирдлагуудтай зөвлөлдөх,
- Оюу Толгой төсөл нь доорхи арга хэмжээнүүдийг авах болно:
 - Монгол талаас авах тусгай зөвшөөрлийг авахад шаардагдах бүхий л үнэлгээ судалгаануудыг хийх,
 - Зээлдүүлэгч талын бүх шаардлагыг биелүүлэхийн тулд БОННБУ-нд нэмэлт тодотгол хийх,
 - Ханбогд сумын ирээдүйд өсч болзошгүй хүн амыг хангах усны тогтвортой эх үүсвэр бэлэн байх явдлыг хангах, энэ нь малчид болон зэрлэг амьтдыг одоо хангаж буй усны эх үүсвэртэй зөрчилдөхгүй байх явдлыг хангах,
 - Төлөвлөгдөж буй орон сууцны болон үйлдвэрлэлийн байгууламжууд эмзэг экосистемд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх явдлыг хангах,
 - Байгууламжуудын байршлын шийдвэр нь сөрөг нөлөөллийг бууруулах болон малчдын бэлчээр нутаг ашиглалтанд сөргөөр нөлөөлөх явдлыг бууруулах,

Оюу Толгой төсөл нь ХӨОГ-нд дурдсанчилан бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх үүрэг хариуцлагаа ухамсарлана .

Ажилчдын орон сууц болон үүнтэй холбоотой цагийн хуваарийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг *Бүлэг D16: Шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнд* тодорхой авч үзсэн.

8.2 ХАМРАХ ХҮРЭЭ

8.2.1 Орон Зайн Хамрах Хүрээ

Төслийн нөлөөллийн бүс нутаг дотор хүн амын шилжин ирэх хөдөлгөөний эрсдэлд өртөх газар нутгуудад Ханбогд сумын төв (уурхайтай хамгийн ойрхон суурин), бүсийн төв Даланзадгад – бусад сумдуудтай харьцуулахад дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ илүү хөгжсөн тул шилжин ирэгсдийн анхаарлыг татаж болзошгүй- зэрэг багтана³. Шилжин ирэгсдийг татах бусад нөхцөлд төслийн үндсэн байршил, бүтээн байгуулалт болон олборлох үйл ажиллагаа өрнөж буй газар нутаг мөн орно. Тухайлбал, уурхай болон зам дагуух байршлууд зэрэг багтана. Хүн амын шилжин ирэх хөдөлгөөнд өртөж болзошгүй нутагт:

- Оюу Толгойн УЛТ-н хашааны гадна,
- Ханбогдоос уурхай хүрэх зам (ялангуяа сүүлийн жилүүдэд хатуу хучилттай болох үед)
- Таван Толгойн нүүрсний уурхай, Гашуун Сухайт дахь Хятад улсын хил хоорондын нүүрс тээвэрлэх зам дагуу байрлах Цагаан Хад суурин буюу хүн ам шилжин ирсэн суурин.⁴
- Оюу Толгой- Гашуун Сухайтын зам дагуу байрлах гурван ажилчдын түр тосгон, Гүний хоолой дахь гүний усны цооногийн талбайгаас УЛТ хоорондын ус дамжуулах хоолой,
- Монгол, Хятадын хилийн шалган нэвтрүүлэх цэг болох Гашуун Сухайт (энэхүү газар нь хилийн тосгон хот болон хөгжих боломжтой) – хэрэв тус газрыг өдөрт 24 цагаар нээлттэй байлгаж, үүгээр хил хоорондын тээвэрлэлт хөдлөгөөн болон худалдааны урсгал мэдэгдэхгүйцээр нэмэгдэх тохиолдолд,
- Төлөвлөгдөж буй Оюу Толгойн ажилчдын аж төрөх суурин болон холбогдох жижиг дунд аж үйлдвэрийн бүс, болон үйлдвэрлэлийн байршлыг тойрсон газар нутаг,
- Оюу Толгой төслийн албан газар үйл ажиллагаагаа явуулдаг Даланзадгад хот (Өмнөговь аймгийн төв) бөгөөл энд төсөл, холбогдох бизнес, тухайлбал нийлүүлэгчдэд зориулсан хөгжлийн төв болон мэргэжлийн сургалтын байгууламжуудад тус тус дэмжлэг үзүүлэх хэд хэдэн бүсийн хэмжээний санаачлагууд бий.

Төслийн нөлөөллийн бүст хамаарагдах бусад сумдууд, тухайлбал Баян-Овоо болон Манлайд хүн амын шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдэж болзошгүй боловч одоогийн байдлаар том хэмжээний эрсдэл биш юм. Учир нь эдгээр байршлууд нь Оюу Толгой төслийн өдөр тутмын үйл ажиллагааны орон зайд хамаарахгүй бөгөөд үйлчилгээ болон дэд бүтцийн хөгжил эдгээр сумдад хангалтгүй, буюу Ханбогд суманд байдаг газруудаас тааруухан байдаг байна.

Ханбогд болон Даланзадгад руу шилжин ирж буй иргэд нь илүү хөгжилтэй дэд бүтэц, ажил эрхлэх боломжруу татагдан ирдэг бөгөөд (албан ба албан бус, шууд ба шууд бус) хөдөө орон нутаг, суурингийн эзлүүд газар нутгийг эзлэн суурьших магадлалтай. Хэрэв энэхүү (нөхөх)⁵ суурьших хөдөлгөөнд зохицуулалт хийхгүй тохиолдолд одоогийн төлөвлөгдсөн суурин газрын даац хэмжээнээсээ хэтэрч, ихэвчилэн зам дагуу баригддаг шугам хоолойн харалдаа шилжилт хөдөлгөөн үүсч иргэд энд ихээр төвлөрөн суурьших болно.


Одоогийн байдлаар хүчин төгөлдөр МУ-ын Газрын тухай хуулийн заалтын дагуу, ялангуяа Монгол улсын иргэн бүрт хашааны 0,07 га газар олгох тухай заалт нь төслийн нөлөөллийн бүс дотор зүй зохистой, хяналт удирдлагатай хот төлөвлөлтийн зорилтонд хүрэхэд хүндрэл болохоор байна. Энэхүү Ханбогд хашааны газар олголт нь эрчимтэй явагдаж байгаа бөгөөд энэ нь хот төлөвлөгчдийн төлөвлөсөн хөгжлийн зорилтонд хүрэхэд саад учруулж байна.

³ Бүлэг D14: Оролцогч болон сонирхогч талуудын оролцооны төлөвлөгөөнд Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс болон үүний бүрэлдэхүүн хэсгүүдийн талаархи дэлгэрэнгүйг авч үзсэнийг үзнэ үү.

⁴ Цагаан Хад нь Оюу Толгой – Гашуун Сухайт, Таван Толгой – Гашуун Сухайт хүртлэх нүүрсний замын уулзварт байрладаг. Оюу Толгой, Гашуун Сухайт хоорондын замын одоогийн шийдэл нь энэхүү байршлыг тойрон өнгөрдөг бөгөөд одоогийн ашиглагдаж буй зам дагуу үүссэн албан бус сууринг шууд дайран өнгөрөхгүй.

⁵ Үүссэн хоосон орон зайг нөхөх

Зураг 8.1 Төслийн нөлөөллийн бүсийг харуулав.



8.2.2 Цаг Хугацааны Хамрах Хүрээ

Уг үнэлгээний цаг хугацааны хамрах хүрээ нь барилгын ажлын үе шат, уурхайг ашиглах үе шат (үйлдвэрлэлийн үе шат), уурхайн үйл ажиллагааны дараах үе шатууд тус тус хамаарна.

Гэвч, Оюу Толгой төсөл ажилчдын суурин болон холбогдох байгууламжуудын байршлыг эцэслэн тогтоогүй тул энэхүү нөлөөллийн үнэлгээний бүлэг нь барилгын ажлын үе шатанд голчлон төвлөрсөн.

Оюу Толгой төслийн ажилчдын суурингийн байршлыг сонгох ба төлөвлөх ажил, Ханбогд сумын төвийг хөгжүүлэх зорилготой Оюу Толгойн төслөөс хэрэгжүүлж буй буюу төлөвлөж буй хөнгөн үйлдвэрлэл болон холбогдох үйл ажиллагаа ба дэд бүтцийн талбайг сонгох ажлын хүрээнд БОННБУ-ний нэмэлт тодотгол хийгдэнэ.

БОННБУ-ний нэмэлт тодотгол нь үйл ажиллагааны болон уурхайн хаалттай холбоотой асуудлуудыг бүрэн авч үзэх болно. Хэдийгээр энэхүү бүлэгт гол гол асуудлуудын дийлэнхийг авч үзсэн боловч бүрэн бүтэн бөгөөд нарийн тодорхой үнэлгээг хийгээгүй. Учир нь Оюу Толгой төсөл ажилчдын сууринтай (улмаар шилжилт хөдөлгөөн) холбоотой олон чухал шийдвэрүүдийг одоогоор гаргаагүй байна.

8.3 ХҮН АМЫН ШИЛЖИН ИРЭХ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

8.3.1 Нөлөөллийн Дүгнэлт

Оюу Толгой төслийн үйл ажиллагаа болон холбогдох ажлууд нь төслийн нөлөөллийн бүсэд шилжин ирэх хүн амын шилжилт нь дараах гол нөлөөлөлд хүргэнэ:

- Байгалийн нөөц, тухайлбал бэлчээр болон усан хангамжинд учруулах дарамтыг нэмнэ,
- Хүн амын тоо өсөж үүнтэй холбоотойгоор бэлчээр болон усны нөөцийн эрэлт ихсэж байгаль орчны доройтол болон биологийн төрөл зүйлийн олон янз байдалд дарамт учруулах болно,

- Өмнөговийн бүс нутагт хүн амын шилжих хөдөлгөөнийг эрчимжүүлж, соёлын ялгаанаас зөрчил үүсч, халдварт өвчний тархалт нэмэгдэнэ,
- Төслийн нөлөөллийн бүс нутаг дотор, ялангуяа Ханбогд сумын нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн хэрэглээ ашиглалтанд нөлөөлнө. Үүнд:
- Дэд бүтэц болон нийтийн үйлчилгээнд үзүүлэх ачаалал нэмэгдэх (эрчим хүч, ундны усан хангамж, бохир ус ба хатуу хог хаягдал цуглуулах цэвэрлэх)
- Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ ба барилга байгууламжуудын ачааллыг нэмэгдүүлнэ.
- Гэмт хэрэг өсөн нэмэгдэх, орчин үеийн хотын амьдралын хэв маягтай холбоотой стрессээс үүдэн хувь хүний аюулгүй байдалд дарамт үзүүлнэ.
- Өсөн нэмэгдэх орлогын түвшин болон эдийн засгийн үйл ажиллагаа нэмэгдэн эд бараа болон үйлчилгээний үнийг өсгөснөөр инфляцийн дарамт үүснэ.
- Бэлэн мөнгөнд түшиглэсэн эдийн засаг уламжлалт эдийн засгийн үйл ажиллагааг орлосноор уламжлалт мал маллах амьдралын хэв маягт дарамт учруулах,
- Оюу Толгой төсөлд ажиллах эрэгтэй ажилчдын тоо нэмэгдсэнээр хүсийн харьцаа алдагдаж архидалт, биеэ үнэлэлт болон бэлгийн дарамт учруулах явдалтай холбоотой хууль эмх журмын асуудал ихсэх байдлыг нэмэгдүүлэх магадлалтай,
- Зохицуулалтгүй бичил уурхайн үйл ажиллагаа дахин гарах зэрэг багтана.

Бүлэг С9: Хөдөлмөр эрхлэлт болон *Бүлэг С7: Эдийн засаг*-т дурдсан ажил эрхлэх боломж болон эдийн засгийн хөгжилтэй холбоотой зэрэг нөлөөллийг энэхүү бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэнгүй.

Дээр дурдсан хам нөлөөллийг бууруулах үндсэн арга хэмжээ нь төслийн нөлөөллийн бүс доторх уурхайн нөлөөлөлд автсан газар нутаг дахь бүсийн хөгжлийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлын дүнд үүснэ.

Бүлгийн үлдсэн хэсэгт хүн амын шилжин ирэх хөдөлгөөнөөс үүдэлтэй бүсийн болон орон нутагт (төслийн нөлөөллийн бүс) үзүүлэх нөлөөлөл, уг сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон түүнийг дэмжих хөтөлбөрүүдийн талаар авч үзсэн. Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсний дараа үлдэх нөлөөллийг тоймлон хүснэгтэнд үзүүлснийг тус бүлгийн төгсгөлд оруулав (Хүснэгт 8.5).

8.3.2 Бүс Нутагт Болон Бүс Нутаг Хоорондын Хүн Амын Шилжилт Хөдөлгөөн

Энэхүү хэсэгт хүн ам шилжих хөдөлгөөний чиглэл, бүс нутгийн хэмжээний (аймаг) ялангуяа Даланзадгад хотын (аймгийн төв) хүн амзүйн динамикийг тусгав.

Нөлөөллийн тодорхойлолт

Аймгийн Төв Даланзадгад Хот руу Шилжин Ирэх Хөдөлгөөн

Оюу Толгой болон Таван Толгойн барилгын материал, тоног төхөөрөмжүүдийн дийлэнхийг Хятад улсаас нийлүүлэх боловч Өмнөговь аймгийн төв болох Даланзадгад хот нь 2 уурхай болон хайгуул болон техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны янз бүрийн шатанд яваа бусад уурхайн төслүүдэд (Даланзадгад хотоос баруун зүгт орших Гурван Тэсийн⁶ ойр орчмын) үйлчилгээ нийлүүлэх Монгол талын гол төв болон өргөжих магадлалтай байна.

Даланзадгад хот нь бусад сумдуудтай харьцуулахад дэд бүтцийн хөгжил давамгайл, орон сууцны боллоцоо илүү, бизнесийн болон амьдрах таатай нөхцөлтэй учир шилжин ирэгсдийн гол анхаарлыг татдаг байна.

Төслийн барилгын үе шатанд ажлын байртай холбоотой шилжин ирсэн хүмүүсийн нөлөөгөөр Даланзадгад хотын хүн ам 10 хүртлэх хувиар өсөх тухай 2007 оны хүн ам шилжин ирэх эрсдлийн

⁶ Гурван Тэс бол Өмнөговь аймгийн нэгэн сум юм. Нарийн Сухайтын нүүрсний уурхай нь тус сумаас зүүн урагш 25 км-д оршино.

үнэлгээнд тусгасан⁷. Оюу Толгойн сургалтын төвүүд (МСҮТ) Даланзадгад хотод байрласнаар энэхүү шилжин ирэх хөдөлгөөн цаашид улам нэмэгдэх хандлагатай юм. (Оюу Толгойгоос зохион байгуулах мэргэжлийн сургалтын талаарх дэлгэрэнгүйг бүлэг С9: Хөдөлмөр эрхлэлт хэсгээс үзнэ үү). Аймгийн удирдлагаас ирүүлсэн сүүлийн үеийн мэдээгээр Даланзадгад хотын хүн ам 2007 онд 17000 байсан бол 2010⁸ онд 19000-д хүрсэн байна. Энэхүү өсөлтөнд нөлөөлсөн хүчин зүйлүүдэд хүн амын энгийн өсөлтөөс гадна шилжин ирэх хөдөлгөөнөөс үүдэх механик өсөлт багтана. 2009 онд Даланзадгад хотын хүн амын өсөлт 12,4 хувьд хүрсэн.

Даланзадгад хотын шилжин ирэгсдийн анхаарлыг татах нэмэлт хүчин зүйлс:

- Монгол улсын бусад газар нутгаас нийлүүлэх уул уурхайн бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний логистик төв,
- Уурхайн ажилчдын орон сууц (АИАБ хуваарь бүхий ажилчдын хувьд),
- Сургалт, боловсролын төв юм.

Эдгээр үйл ажиллагаанууд нь хүн амын тогтмол өсөлтөнд нөлөө үзүүлнэ.

Даланзадгад хот нь бүсийн хүн ам шилжин ирэх хөдөлгөөний төв болохоос гадна төслийн нөлөөллийн бүс дэх бусад нөлөөллийн сумуудтай харьцуулахад энэ нь хүн ам шилжин ирэх хөдөлгөөнийг хүлээн авах чадвартай юм. Энэхүү уян хатан байдал нь доорхи шалтгаантай холбоотой:

- Барилгын ажилтай холбоотой Даланзадгад хотруу шилжин ирэх хөдөлгөөн цар хүрээ (Оюу Толгойн ажиллах хүчний хэрэгцээнээс үүдэлтэй) нь үндсэн хүн амын хэмжээнд харьцуулахад бусад цөөн хүн ам бүхий сумтай харьцуулахад бага юм.
- Даланзадгад хот нь илүү их хэмжээний, чадварлаг ажиллах хүчтэй бөгөөд тэдгээрийн ихэнх нь Оюу Толгой болон өөр бусад уурхайн төслүүдэд барилгын болон үйл ажиллагааны үе шатуудад тэнцэн ажиллах боломжтой. Ингэснээр хүмүүсийн орлого нэмэгдэж Даланзадгад хотын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр үзүүлнэ.
- Аймгийн төв учраас Даланзадгад хотын засаг захиргаа нь чадварлаг, төсвийн нөөц ихтэй, шаардлагатай тохиолдолд Засгийн газраас хуваарилах нөөцийг нэмэгдүүлэх чадамж нь илүү.
- Төслийн нөлөөллийн бүсийн бусад сумтай харьцуулахад Даланзадгад хотод нийгмийн үйлчилгээ болон байгууламжийн хувьд дэд бүтцийн хөгжлөөр давуу.
- Даланзадгад хотод (байнгын орон сууц) илүү чанартай орон сууцны хангамж байдаг бөгөөд хувийн барилгын ажил хийдэг гэрээт гүйцэтгэгч нар өсөн нэмэгдэж буй орон сууцны захиалгыг гүйцэтгэх боломжтой.
- Өсөн нэмэгдэж буй хүн амын хэрэгцээг хангахуйц худалдаа үйлчилгээний компаниуд бий .

Даланзадгад хотын бизнес эдийн засгийн таатай орчин, өндөр амьжиргааны түвшин, идэвхитэй эдийн засаг зэрэг нь төслийн нөлөөллийн бүсийн бусад сумдаас Даланзадгад хот руу шилжих хүн амын бүс нутгийн шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлж магадгүй. Нөгөө талаас энэхүү хандлага нь Ханбогд болон Цогтцэций сумын уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор хөгжих хөгжлөөр тэнцвэржих боломжтой (Оюу Толгой болон Таван Толгой) бөгөөд уурхайтай холбоотой хөрөнгө оруулалт, орлогын үр дүнд эдийн засгийн гүйцэтгэл сайжрах явц нь эргээд эдгээр төвүүд Өмнөговийн бүс нутгийн хэмжээнд худалдаа эдийн засгийн зангилаа төв болох нөхцлийг бүрдүүлнэ.

Даланзадгад сум руу шилжин ирэх хөдөлгөөнтэй холбоотой болзошгүй асуудлуудад хотын захад зөвшөөрөлгүй гэр⁹ хороолол үүсэх, улмаар эрүүл ахуй, энгийн үйлчилгээний хомсдол, аюулгүй байдлын хангалтгүй байдал, төрөл бүрийн нийгмийн сөрөг үзэгдлүүд (тухайлбал: ядуурал, архи дан

⁷ Барклей энд Ассосиэтэс 2007. Оюу Толгой: Шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ. Айвенхоу Майнз Монголиа Инк болон Рио Тинто-д зориулан боловсруулсан тайлан.

⁸ Хүн амын тооллогын мэдээ 2010, Үндэсний Статистикийн Хороо

⁹ Гэр бол Монгол үндэсний эсгийгээр хийсэн, зөөвөрлөж болох сууц юм.

согтуурал, мансууруулах бодисын хэрэглээ, хууль бус худалдаа, биеэ үнэлэлт г.м) орно. Эдгээр асуудлууд илэрсэн тохиолдолд төр захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран түргэн шуурхай арга хэмжээ авч, нарийн хяналт тавих шаардлагатай.

Бусад Сумын Төвүүдэд Шилжин Ирэх Хүн Амын Хөдөлгөөн – Баян-Овоо, Манлай

Ханбогд сумтай ойролцоо, төслийн нөлөөллийн бүс дэхь зэргэлдээх Баян-Овоо, Манлай сумуудад 2 чиглэлийн хүн амын шилжилт хөдөлгөөн ажиглагдсан. Үүнд: Уурхайн ажил горилох, эдийн засгийн боломж эрэлхийлэх зорилгоор Ханбогд болон Цогтцэций сумруу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн болон ажил эрэлхийлж бусад алс зайд орших газруудаас шилжин ирэх хөдөлгөөн орно.

Ханбогд сум, түүний зэргэлдээх сумуудад – Даланзадгад, Баян-Овоо, Манлай – сүүлийн үед ажиглагдаж байгаа хандлага нь малчид хот газар луу шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор ялангуяа сумын төвд хүн амын нягтрал ихсэх явдал юм. Үүнд нөлөөлж буй хүчин зүйлст:

- Үйлдвэрлэлийн улмаас бэлчээрийн доройтол үүсэх, газаргүй болох,
- Зуд¹⁰ ба уул уурхай, уур амьсгал болон бусад асуудалтай холбоотойгоор малчдын амьдарлын хэв маяг өөрчлөгдөх,,
- Дэлхийн санхүүгийн хямрал, байгалийн сөрөг үзэгдэл, олон дахин ургац муутай жилүүд давтагдахтай холбоотойгоор амьтны гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн эргэн сэргэлт удаашрах зэрэг багтана.

Цогтцэций Сумруу Чиглэх Хүн Амын Шилжилт Хөдөлгөөн

Эдгээр хүчин зүйлүүд нь байгалийн нөөцөөс амьжиргаа нь шууд хамааралтай малчдад Оюу Толгой ХХК болон бусад үйлдвэрлэлийн төслүүдэд ажил горилох, тухайлбал Баян-Овоо дахь коксжих нүүрсний уурхай болон Цогтцэций сум дахь нүүрсний төслүүдэд ажил эрэлхийлэх хувилбар хандлагыг үүсгэж байна. Цогтцэций суманд Энэржи Ресурс ХХК-ий үйл ажиллагаа явуулж эхэлсэн Ухаа Худагийн нүүрсний уурхай болон Таван Толгойн коксжих нүүрсний уурхайтай холбоотойгоор шилжин ирэх хүн амын шилжилт хөдөлгөөн саяхнаас эрс нэмэгдсэн. Оюу Толгой Цогтцэций хооронд 120 км зайтай тул тэнд өрнөж буй хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой суурьшилтын үйл явц нь Оюу Толгой төслийн бүс нутаг болон Ханбогд суманд шууд нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

Одоогийн суурин байгаа хүн амын тоо болон ажил эрхлэлтийн хэрэгцээнд үндэслэн харахад Оюу Толгой болон тус аймаг дахь бусад уул уурхайтай холбоотой хүн амын шилжин ирэх хөдөлгөөн (ялангуяа Таван Толгой¹¹) нь ирэх 10 жилд аймгийн хүн амыг 2 дахин нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Бүс Нутгийн Төлөвлөлт Болон Дэд Бүтэц (БНТДБ)

Төсөл нь бүсийн болон орон нутгийн удирдлагад хүн амын шилжилт хөдөлгөөн болон түүнтэй холбоотой нөлөөллийн эсрэг хамтарсан арга хэмжээ авах явдалд дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээ Оюу Толгой ухамсарладаг. Энэхүү дэмжлэгийг Оюу Толгойн Бүсийн Төлөвлөлт болон Дэд Бүтцийн хэлтэс Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Монгол улсын Засгийн газраас үндэслэн байгуулсан Өмнийн Говийн Бүсийн Хөгжлийн Зөвлөл (ӨГБХЗ) - тэй хамтран хэрэгжүүлнэ. Оюу

¹⁰ Зуд гэдэг бол “Цагаан үхэл” хэмээх Монгол үг бөгөөд асар хүйтэн температур их хэмжээний цасан бүрхүүл болон арктикийн хүчтэй салхитай хавсран хахир хатуу өвлийг илтгэнэ. Гантай зуны дараа ийм өвөл залгах бөгөөд үүний дараа хавар нь цас хайлан зудыг олон төрлийн үзэгдэл бүхий байгалийн гамшиг болгодог юм. 2009-2010 онд шилжих өвлийн зудны дүнд 2010 оны 4-р сарын байдлаар 7.8 сая толгой мал сүрэг (Монгол орны нийт мал сүргийн 17 %) улс даяар хорогдсон байна. Хүмүүнлэгийн тусламжийн уриалга Монгол 2010-Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүмүүнлэгийн тусламжийн асуудал эрхэлсэн газраас гаргасан Зудны уриалгыг үзнэ үү.

<http://ochaonline.un.org/humanitarianappeal/webpage/asp?Page=1856>

¹¹ Монгол улс дахь хамгийн том нүүрсний орд, дэлхийн эхний 10-т багтах Таван Толгойн орд газар нь 2007 онд 1 сая тонн нүүрс олборлож экспортлосон. Эх сурвалж: <http://tavantolgoi.mn/>

Толгойн (ӨГБХЗ) санаачлагын эрхэм зорилго нь бүс нутгийн тэнцвэртэй, тогтвортой төлөвлөлт болон төслийн нөлөөллийн бүс дэх холбогдох дэд бүтцийн асуудлыг Засгийн газар болон орон нутгийн захиргаатай хамтран шийдвэрлэх явдал юм.

ӨГБХЗ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн санаачлагуудад:

- Ханбогд сумын төвийг ундны усны байнгын эх үүсвэрээр хангах зорилгоор орон нутаг дахь гүний усны эх үүсвэрийг олборлох мөн их хэмжээний усан хангамжийн дэд бүтцийг байгуулах,
- Оюу Толгойн уурхайгаас Ханбогд сумын төв хүртэлх 35кВ-ын цахилгаан дамжуулах шугам барих ажлыг гүйцэтгэж урт хугацааны, тогтвортой эрчим хүчний эх үүсвэртэй болгох,
- Ханбогд сумын төвтэй холбох хайрган хучилттай замын сүлжээг байгуулах
- Даланзадгадад Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв байгуулах,
- Олон тооны сурагчдыг багтаах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Ханбогд сумын төвийн сургууль болон цэцэрлэгүүдийн өргөтгөлүүд хийх асуудлууд багтана.

Өмнийн говийн бүс нутгийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээний 4-р хэсэгт Монгол улсын Засгийн газар ӨГБХЗ-г байгуулж, түүний үйл ажиллагааг дэмжин ажиллана хэмээн заасан байдаг. Мөн зөвлөл нь өөрийн удирдлагын зөвлөлөөр удирдуулах бөгөөд энэхүү удирдлагад Засгийн Газар, Орон нутгийн захиргааны байгууллага, Өмнийн Говийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, үйл ажиллагаа нь Өмнөговийн бүс рүү чиглэгдсэн олон улсын санхүүгийн институт, донор байгууллагын төлөөллүүдийг оролцуулахаар санал оруулсан байдаг. Хөрөнгө Оруулалтын гэрээнд зааснаар хөрөнгө оруулагч (Оюу Толгой) нь энэхүү зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн байж, зөвлөл ба түүний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлнэ. Зөвлөл нь эргээд Засгийн Газарт дараах чиглэлүүдээр дэмжлэг үзүүлнэ. Үүнд, Өмнийн Говийн бүсийн болон орон нутгийн болон бүсийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө болон төсөвийг боловсруулах, санхүүжүүлэх, зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэг багтана:

- Хүн амын шилжилт хөдөлгөөний зохицуулалт,
- Бүсийн болон орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлж, хариуцлагатай ил тод засаглалыг хөхүүлэн дэмжих,
- Хот төлөвлөлт, хөгжилтэй холбоотой тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх тухайлбал зам, эрчим хүч, усан хангамж, дулаан, бохир усны систем,
- Англи хэл болон мэргэжлийн сургалт зэрэг албан болон албан бус сургалтуудыг зохион байгуулах,
- Хүн амын эрүүл мэндэд анхаарч, үзлэг оношилгооны төвүүд, соёлын төвүүд, спортын төвүүдийн бариллагжуулалт, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах,
- Орон нутгийн захиргаа болон иргэний нийгмийг чадавхижуулах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Дээр дурдсан зүйлсээс гадна уг гэрээнд хөрөнгө оруулагч нь Өмнөговийн засаг захиргааны хэрэгжүүлж буй нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, Оюу Толгой төслийн тогтвортой үр ашиг нь Монгол улсын иргэд тэр дундаа Өмнөговь аймгийн ард иргэдэд хүртээмжтэй байх явдлыг хангахын тулд хамтран ажиллана.

Оюу Толгойн бүсийн хэмжээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл нь дээр дурдсан хүрээнд зохицуулагдах бөгөөд бүс нутгийн ба орон нутгийн ба захиргаа, олон нийт болон бусад холбогдох оролцогч талуудтай зөвшилцсөний дүнд боловсруулагдан хэрэгжиж, ингэснээр хөгжлийн зорилгод тулгуурласан нэгдсэн зөвшилцөлд хүрч төлөвлөгөөнүүдийг бодитойгоор хэрэгжүүлэх үр дүнтэй стратеги хамтын ажиллагаа үүсэх болно.

Бүсийн Хөгжлийн Хөтөлбөр Болон Өмнөговьд Хэрэгжиж Буй Бусад Санаачлагуудтай Хамтран Ажиллах

Оюу Толгойн бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийн дутагдал, төсөлд тулгараад байгаа хөгжлийн асуудлуудыг шийдэх **Бүс Нутгийн Хөгжлийн Хөтөлбөрийг** боловсруулсан.

Энэхүү Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхийн тулд Оюу Толгой нь Мянганы Хөгжлийн Зорилтуудыг (МХЗ)¹² макро түвшинд удирдлага болгодог. Энэхүү хөтөлбөр нь төслийн нөлөөллийн бүс нутаг дахь сумуудын дэд бүтцийг хөгжүүлэх асуудлаар Оюу Толгой болон Засгийн Газар, аймгийн болон орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллахад анхаарах болно. Ялангуяа Оюу Толгойн төлөөлөл байдаг Өмнөговь бүсийн хөгжлийн зөвлөлтэй хамтран ажиллаж, хөгжлийн нэн тэргүүний асуудлуудыг шийдвэрлэх болно. Оюу Толгойгоос улсын төсөвт орох орлогоос төслийн нөлөөллийн бүс нутгийн сумдын дэд бүтцийг хөгжүүлэхэд Засгийн Газраас жинтэй хэмжээг төсөвлөхийг Оюу Толгой төсөл дэмжинэ. (Төсөл хэрэгжсэнээр улсын төсөвт оруулах орлогын талаарх дэлгэнгүйг бүлэг С7: Эдийн засгийн нөлөөлөл хэсгээс үзнэ үү)

Оюу Толгойн Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр нь Ханбогд сум болон Өмнөговь аймгийн бусад ойролцоох сумдуудад төвлөрч, Ханбогд болон түүний дэд бүсүүдийн тогтвортой хөгжилд дараах замаар эерэг нөлөө үзүүлнэ:

- Ажилчдын тав тухтай орон сууцыг бий болгох,
- Ханбогд суманд хөнгөн үйлдвэрлэлийн байгууламжийг хөгжүүлэх,
 - Орон нутгаас ажиллах хүч авах.

Төслийн бүс нутаг хөгжүүлэх стратеги мөн дараах зүйлсээс бүрдэнэ:

- Монгол улсын Засгийн Газар, бусад хөгжилтэй холбоотой хамтрагч түншүүд болон донор байгууллагуудтай хамтран Оюу Толгой нь Ханбогд болон түүний бүс нутгийн хөгжил, төлөвлөлтөнд идэвхитэй оролцоно,
- Оюу Толгой нь Ханбогд сумыг дэд бүсийн төв болгон хөгжүүлэх ажилд корпорацийн шууд хөрөнгө оруулалт болон олон нийтийн болон хувийн компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих замаар туслалцаа үзүүлнэ,
- Оюу Толгойн хотын болон бүс нутгийн хөгжилд үзүүлэх туслалцаа нь Засгийн Газар болон орон нутаг төлөвлөлттэй нягт уялдаж, төлөвлөлтөнд суурилсан дэд бүтэцэд чиглэсэн байна.

Бүс нутгийн хөгжлийн стратегийн нэг хэсэг болгож төсөл нь дараах үйл ажиллагааг яаралтай авч хэрэгжүүлэн өөрийн стратеги зорилтуудаа гүйцэлдүүлнэ. Үүнд:

- Зөвшилцөл болон ойлголцлыг бүрдүүлэхийн тулд дотоод болон гадаад оролцогч талуудыг оролцуулах мөн Бүс нутгийн хөгжил болон ажиллах хүчний орон сууцны асуудлаар ажлын хэсгийг байгуулах,
- Боломжтой орон сууцны төлөвлөгөө, хувилбаруудыг судлан тодруулна,
- Бүс нутгийн хөгжил болон орон сууцжуулалтанд туслалцаа үзүүлэх зорилгоор Оюу Толгойн удирдамжыг боловсруулна. Үүнд: Нийгмийн үйлчилгээний нийт байгууллагуудыг санхүүжүүлэх боломж ба стратегийн хамтын ажиллагаа ба хөрөнгө оруулалтын боломжуудад анализ хийх багтана. Энэ нь хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан байх бөгөөд (энэ нь олон нийтэд нээлттэй баримт бичиг байна) энэ нь одоогийн байдлаар Оюу Толгой ХХК болон төслийн нөлөөллийн бүсд хамрагдах сумдын хооронд боловсруулагдаж байна.

Азийн Хөгжлийн Банк нь Монгол улсын Засгийн Газрын хамтаар Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлэхэд зориулж 21,9 сая ам.долларын хөрөнгө оруулахаар баталсан. Үүнээс ойролцоогоор 15 сая ам.доллар нь Азийн хөгжлийн банкнаас аймаг болон сумын засаг захиргаанд үзүүлсэн туслалцаа бөгөөд үлдсэн төгрөгийг Монгол улсын Засгийн Газар (6,8 сая) ба аймгийн захиргаа (0,1 сая ам.доллар)¹³ тус тус гаргавгу. АХБ-ны дэмжлэг туслалцаа нь Дорно болон

¹² Зорилтууд нь ядуурлыг бууруулах, нийтээрээ боловсролтой болох, хүйсийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхижуулах, эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад тус тус чиглэгдсэн. МХЗ-д зориулсан НҮБ-ын цахим хуудас <http://www.un.org/millenniumgoals/>, мөн Монгол улсад хэрэгжиж буй НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн талаар <http://www.undp.mn/mdg.html> хуудаснаас үзнэ үү.

¹³ Азийн хөгжлийн банк. Зүүн өмнөд говийн хот болон хилийн чандын хотын хөгжил хөтөлбөр. URL эх сурвалж: <http://www.adb.org/projects/project.asp?id=42184>

Өмнөговийн¹⁴ сумын төвүүдэд төвлөрөх бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилт нь 2011 онд эхлэсэн. Уг хөтөлбөрийн ач тусыг хүртэх сумуудын нэг нь Ханбогд сум байх ба туслалцааг дараах үндсэн хоёр чиглэлээр өгнө:

- Байгууллагын хөгжил болон чадавхижуулалт:
 - Дэд бүтцийн үйлчилгээг шинэчлэх, үүнд хотын үйлчилгээний хангамжийг гүйцэтгэлд-үндэслэсэн гэрээнд шилжүүлэх
 - Хот төлөвлөлт, бодлого боловсруулалтыг сайжруулах зохион байгуулалтын хөгжил болон чадавхижуулалт
 - Хотын хөгжлийн асуудлаарх бүсийн хамтын ажиллагааг сайжруулах
 - Хил дамнан Хятад улстай хамтран ажиллах
- Дэд бүтэц сайжруулах нэн тэргүүний асуудлууд:
 - Усны нөөц олборлох, дамжуудалт, хадгалалт, түгээлт, мөн шугам хоолойгоор усан хангамж дамжуулах боломжтой болгож, усны системийн шүүрэлтийг багасгах,
 - Бохир ус цуглуулах явдлыг нэмэгдүүлэх, бохир ус цэвэрлэх болон үйлдвэрийн хаягдал шингэнийг дахин ашиглах чадамжийг сайжруулах,
 - Дүүргийн халаалтын хангамжийг сайжруулж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх,
 - Эрчим хүчний түгээлтийг өргөтгөх, ялангуяа гэр хорооллын айл өрхөд,
 - Хатуу хучилттай төвлөрсөн замын сүлжээ,
 - Хатуу хог хаягдлын зохион байгуулалттай хогийн цэгийг бий болгож, хатуу хог хаягдал цуглуулах чадамжийг сайжруулах, мөн
 - Үерийн ус зайлуулах шугам хоолойг сайжруулах.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь 2011 онд эхэлсэн Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг (Оюу Толгой ХХК-н санхүүжүүлж буй бүсийн хөгжлийн үйл ажиллагаануудаас гадна) дэмжсэн бөгөөд АХБ-ын хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь Ханбогд сумын хувьд тус хөтөлбөрийн үйл ажиллагаанууд нь Оюу Толгой төслөөр дамжуулан зохион байгуулагдаж байна. АХБ-ны дэмжлэг үзүүлж буй хөтөлбөр нь хувийн секторын оролцоог нэмэгдүүлж, гүйцэтгэлийг хариуцлагатай болгох зорилгоор Засгийн газрын сүүлийн үеийн бодлогын өөрчлөлтүүдэд дээр суурилсан. Энэ нь 2010 оны 2-р сард батлагдсан Концессийн тухай Монгол улсын хуулийн заалтуудыг дагаж мөргөх ба энэ нь хувийн хэвшил болон төрийн түншлэлийн (ХХТТ) хууль эрх зүйн үндсийг тавьсан байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд, Засгийн газар нь шилжитийг хөнгөвчлөхийн тулд мөн хотын захиргааны үйлчилгээний талаарх хуульд орох дүрэм журам, заалтыг боловсруулж, ажил хэрэг явуулахад дэмжлэг үзүүлэхийн тулд ХХТТ-ын хэлтсийг байгуулсан. Оюу Толгойн хот болон бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх ажил нь Засгийн газар болон энэ чиглэлээр ажиллаж байгаа АХБ-ны үйл ажиллагаануудтай нягт уялдаатай байна.

Оюу Толгой ХХК нь дараах санаачлагуудаар дамжуулан Даланзадгад хотод хэрэгжиж буй хөгжлийн болон төлөвлөлтийн үйл ажиллагаануудыг мөн дэмжин ажиллаж байна. Үүнд:

- Аймгийн төвийн орон нутгийн захиргаа, төлөвлөлтийн удирдлагын чадавхийг сайжруулж, техникийн туслалцаа үзүүлэх,
- Аймгийн төвийн ирээдүйн усны хэрэгцээг хангахуйц, хайгуул хийж олборлож болох усны шинэ эх үүсвэрүүдийг тодорхойлох
- Хатуу хог хаягдлын менежментэд дэмжлэг үзүүлэхийн тулд тоног төхөөрөмж, техникийн туслалцаа үзүүлэх,
- Спорт, урлагын шинэ төвүүдийг байгуулах,
- Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төвийг байгуулах зэрэг багтана

¹⁴ Өмнөговийн бүс дэх Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурван тэс сумууд ба Дорноговийн бүс дэх Замын Үүд ба Сайншанд

Түүнчлэн, Оюу Толгой ХХК нь Өмнөговь аймаг болон нөлөөлөлд өртөж буй дөрвөн сумын удирдлагуудтай хөгжлийн төлөвлөгөө болон дэд бүтцийн хөгжлийн дэмжлэгийн талаар Хамтын Ажиллагааны Гэрээний хамрах хүрээний талаар тохиролцох шатандаа явж байна.

Нөлөөллийн эрчим

Оюу Толгой төслөөс үүдсэн бүс хоорондын хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сөрөг нөлөөлөл нь хязгаарлагдмал хүрээнд үйлчлэх, тохиолдох магадлал болон дунд хугацаанд үргэлжилнэ гэдэг утгаараа **дунд зэргийн сөрөг нөлөөлөлт**эй байна хэмээн үзэж байна, Бүс хоорондын хүн ам шилжих хөдөлгөөний нөлөөлөл нь төслийн барилгын ажил болон уурхайн үйлдвэрлэлийн үе шатуудад үргэлжилнэ. Оюу Толгой төслийн Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр ба Оюу Толгойн Орон Нутаг Нийгмийн Асуудал Эрхэлсэн Хэлтэс болон Бүсийн Хөгжлийн газраас (орон нутаг, бүсийн төлөвлөлт болон дэд бүтцийн хэлтэс (ОНБТДБХ) санаачилж буй бусад үйл ажиллагаануудын хэрэгжилт нь Өмнийн Говийн Бүс нутгийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлын хамтаар энэхүү сөрөг нөлөөллийн ерөнхий эрчимийг **бага түвшинд** хүртэл бууруулах боломж олгоно.

8.3.3 Төслийн Нөлөөллийн Бүс рүү Шилжих Хүн Амын Шилжилт Хөдөлгөөн

Энэхүү хэсэгт Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс нутаг, ялангуяа Ханбогд сумруу шилжих хүн амын урсгалын өнөөгийн төлөв, шилжих хөдөлгөөнтэй холбоотой үүсэх янз бүрийн сөрөг нөлөөллийн талаар тус тусгав.

Хүн ам шилжин ирэх хөдөлгөөний урьдчилсан тооцоололт

Оюу Толгой ХХК нь сумын төвшний хүн амын төлөвийн тооцоолол хийсэн бөгөөд үүнийг Хүснэгт 8.2-т харуулав. Эдгээр тооцоонуудыг хийхдээ АХБ-ны Зүүн өмнөд Говийн¹⁵ хүн амын проекц хийхэд ашигласан аргачлалыг ашигласан боловч хамгийн сүүлийн үеийн мэдээлэлд үндэслэн бага зэргийн өөр таамаглалуудыг дэвшүүлсэн болно. Энэхүү тооцоонд Даланзадгад хотод ажиглагдсан хүн амын шилжин ирэх хөдөлгөөний өндөр түвшний (өмнөх хэсэгт дурьдсанчлан АХБ-ны анхны тооцоололтоос хэтэрсэн) мэдээлэл багтаж, Оюу Толгойн хувьд Ханбогд-төвтэй орон сууцны бодлого хэрэгжүүлэх хэрэгтэйг баталсан (урьд нь тооцоолж байсан тараан байрлуулах орон сууцны бодлогын оронд) ба Оюу Толгой төсөл хэрэгжснээр эрчимжих Ханбогд сумын хөгжлийн өөр хандлагын таамаглал, тухайлбал шинэ өмч хөрөнгийн бүтээн байгуулалт, нийлүүлэлтийн сектор болон үйлчилгээ төвтэй бизнес зэрэг багтсан. Доорх хүснэгтэнд Ханбогд сумын хүн амын тоонд гарах гол өсөлтийг харуулав.

Хүснэгт 8.2: Сумын хэмжээний хүн амын өсөлтийн төлөв, 2010 - 2020 он хүртэл

| Сумын төв | Ирээдүйн болзошгүй үйл ажиллагаа (болон Оюу Толгой төслийн талбай хоорондын зай) | Албан ёсны хүн ам, 2010 оны тооллого (бодит түвшин) | Хүн амын өсөлтийн төлөв (урьдчилан тооцоолсон түвшин) | | |
|-------------|--|---|---|--------|--------|
| | | | 2010 | 2015 | 2020 |
| Даланзадгад | Уул уурхайн бүсийн төв (250 км) | 18,746 | 17,000 | 22,600 | 30,000 |
| Ханбогд | Оюу Толгой төслийн хотын үйлчилгээний үндсэн төв (45 км) | 3,522 | 3,500 | 14,000 | 20,000 |
| Манлай | Дагуул хотын төв (120 км) | 2,441 | 2,000 | 2,400 | 3,000 |

¹⁵ Азийн Хөгжлийн Банк. Зүүн Өмнөд Говийн Хот болон хил орчмын хотын хөгжил төсөл.

Эх сурвалж: <http://www.adb.org/projects/project.asp?id=42184>

| Сумын төв | Ирээдүйн болзошгүй үйл ажиллагаа (болон Оюу Толгой төслийн талбай хоорондын зай) | Албан ёсны хүн ам, 2010 оны тооллого (бодит түвшин) | Хүн амын өсөлтийн төлөв (урьдчилан тооцоолсон түвшин) | | |
|-----------|--|---|---|-------|-------|
| | | | 2010 | 2015 | 2020 |
| Баян Овоо | Дагуул хотын төв (80 км) | 1,600 | 1,500 | 1,800 | 2,200 |

Эх сурвалж: Оюу Толгойн бүсийн хөгжлийн баг 2010, Ханбогд сумын засаг даргын тамгын газар 2010.

Ханбогд сум нь хөрш зэргэлдээ сумуудтай харьцуулахад (Цогтцэций сумаас бусад нь)¹⁶ хамгийн өндөр өсөлтийн түвшинтэй байв. 2000 – 2009 оны хооронд Ханбогд сумын хүн амын өсөлт жилд 4,2 хувьтай байсан нь үндэсний дундаж өсөлтөөс өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь Оюу Толгойн барилгын ажлын эхний шаттай холбоотой. 2010 оны тооллогод үндэслэсэн хүн амын өсөлт 11% хүрсэн ба энэ нь уул уурхайн үйл ажиллагаа эрчимжсэний улмаас Ханбогд сум хүн амын прогрессив өсөлттэй гол төв болон хувирсаныг илтгэж байна (Ханбогд сумын хүн амзүйн мэдээллийн талаарх дэлгэрэнгүй тайлбарыг бүлэг В8: Хүн ам ба хүн амзүй – гээс үзнэ үү).

АХБ-ны хийсэн урьдчилсан тооцооноос харахад Ханбогд сумын хүн ам 2020 онд их хэмжээгээр өсөх хандлагатай байна. (2010 оны тооллогоор 3522, 2015 онд 14000, 2020 онд 20000-т хүрэх)¹⁷

2007 онд хийгдсэн Оюу Толгойн хүн амын шилжилт хөдөлгөөний үнэлгээний дараа төслийн талбай дээрхи барилгын ажиллах хүчний талаарх мэдээлэл төсөлд орсон өөрчлөлтүүдийг тусган шинэчлэгдсэн болно. Дараах хүснэгтэнд хүн амын шилжилт хөдөлгөөний өмнө хийгдсэн урьдчилсан тооцоог шинэчлэх харуулсан ба ингэхдээ ижил аргачлал ашигласан.

Хүснэгт 8.3 Оюу Толгойн барилгын ажлын үеийн ажиллах хүч (жилийн дундаж үзүүлэлт) болон хүн амын шилжилт хөдөлгөөний шинэчлэгдсэн тооцоолол.

| Жил | Оюу Толгойн ажиллах хүч болон гэрээт гүйцэтгэгчдийн тоо | | | Шилжин ирэх хүн амын тооцоо (шилжин ирэгсдийн тоо) | |
|------|---|--------|--------|--|-----------------------|
| | Монгол | Гадаад | Нийт | Өндөр (0.1 илтгэгцүүр) | Бага (0.3 илтгэгцүүр) |
| 2009 | 1,009 | 170 | 1,179 | 1,009 | 303 |
| 2010 | 4,331 | 1,634 | 5,964 | 4,331 | 1,299 |
| 2011 | 7,426 | 5,477 | 12,903 | 7,426 | 2,228 |
| 2012 | 6,184 | 3,844 | 10,028 | 6,184 | 1,855 |
| 2013 | 3,533 | 561 | 4,094 | 3,533 | 1,060 |
| 2014 | 2,903 | 477 | 3,380 | 2,903 | 871 |

Эх сурвалж: Оюу Толгойн ажиллах хүчний мэдээллийн сан

Гадаадын ажиллах хүчний тоог бүрэн гүйцэт тусгасан бөгөөд Хятад улсын барилгын ажиллах хүч нь шилжин ирэх хүн амын өсөлтийн үндсэн хүчин зүйл биш юм. Хятад улсын ажилчид Оюу Толгойн төслийн үндсэн талбай дахь бүрэн үйлчилгээтэй сууринд, ус хангамжийн шугам дагуух байршлууд, Хятад улс Оюу Толгой хоорондын зам дагуух дагуулсуурингуудад амьдарсаар ирсэн бөгөөд цаашид ч амьдрах болно. Төслийн дараа Хятад ажилчид БНХАУ руу нутаг буцна. Эдгээр ажилчид орон нутгийн ард иргэдтэй харилцаа тогтоох болон орон нутаг худалдаа хийх гарахгүй бөгөөд энэ нь гагцхүү Оюу Толгойн уурхайн лицензтэй газар доторх дэлгүүр, худалдааны төвүүдээр үйлчлүүлэх явдлаар хязгаарлагдана.

Хүснэгт 8.3 – ын баруун 2 баганад Оюу Толгойн барилгын ажлын үе шатны үйл ажиллагаатай холбоотой хүн амын шилжилт хөдөлгөөний тооцооллыг харуулав. Энэхүү хүн амын шилжилт ирэх хөдөлгөөний тооцоолол хийхдээ Оюу Толгойн төслийн уурхай дээрх тухайн жилд ажиллаж буй нийт Монгол ажилчдын тоо хэмжээнд энгийн илтгэгцүүрийг ашиглан тооцсоноор гаргасан. 1.0

¹⁶ Оюу Толгой төслийн нийгэм, Эдийн засаг, Байгаль орчны хэлтэс, Бодлого Судлалын Төв, Хүн амын сургалт болон судалгааны төв, 2009

¹⁷ Зүүн Өмнөд Говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл, РРТА төслийн тайлан, нэмэлт хавсралт А, Азийн Хөгжлийн Банк, 2009 оны 11 сар.

илтэлцүүрийг ашигласан нь өндөр гарч харийн 0.3 илтгэлцүүрийг ашигласан нь бага утгатай гарсан болно.

Монгол орны нөхцлийн хувьд эдгээр итгэлцүүрүүд нь урьдчилсан таамаглалын түвшинд байна. Энэ нь Оюу Толгой төслийн том цар хүрээ мөн урьдны судалгааны мэдээллийн сан дутмаг зэрэгтэй холбоотой. 2006 оны 12-р сарын байдлаар сүүлийн 3 жил дэх Ханбогд суманд бүртгэгдсэн шилжин ирсэн хүний нийт тоо (явсан тоо бага) 300 байв. Үүнтэй харгалзах Оюу Толгой төсөлд ажиллах ажилчдын тоо нийт 1200 байв. Энэ хязгаарлагдмал ажиглалтаас үзэхэд шилжин ирсэн хүн ам нь “0.25 х Оюу Толгойн ажиллах хүч” гэсэн хамааралтай тэнцүү байна. 2009 оны 12-р сар болон 2011 оны 6-р сарын хооронд, барилгын ажлын нийт ажиллах хүчний тоо 867-с 14,000 хүртэл өсч Ханбогд сумын төв дэхь нийт бүртгэгдсэн шилжин ирсэн хүн амын тоо 200 хүрсэн ба энэ хугацаанд бүртгэгдээгүй хүн ихэссэн тухай мэдээ байхгүй байна. Энэхүү нөхцөл байдал нь төслөөс өнөөг хүртлэх хүн амын шилжилт хөдөлгөөний тал дээр амжилттай хэрэгжүүлсээр ирсэн менежментийн үр дүн юм. Гэвч энэ нөхцөл байдал уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлэснээр өөрчлөгдөх болно. Дэлхийн бусад орнуудад, тухайлбал Африк болон Индонезид, барилгын ажлын үе дэх хүн амын шилжилт хөдөлгөөний тооцоолол хийхэд илүү өндөр үзүүлэлттэй илтгэлцүүрүүд болох 3 эсвэл 4-ийг хэрэглэж ирсэн туршлага байдаг байна. Эдгээр орнууд нь Монгол улсыг бодвол их хүн амтай ба хүн амын нягтрал ихтэй. Дээрх орнууд нь олон тооны ажиллах хүч болон дагалдан ирэх хүн амын шилжилт хөдөлгөөн (төслөөс төслийн хооронд дамжин шилждэг уурхай дагасан, бүлгийн зохион байгуулалтанд орсон хүмүүс байдаг) дагуулсан том уурхайн төслүүд хэрэгжүүлсэн туршлагатай байдаг бөгөөд эдгээр ажиллах хүчнүүд нь барилгын ажил, суурингуудын хэрэгцээ шаардлага хангахуйц төрөл бүрийн ажил хийх болон бусад үйлчилгээ нийлүүлэх туршлагатай байдаг. Барилгын ажлын суурингууд нь эдгээр уурхай дагасан бүлэглэлүүдийн нийлүүлэх үйлчилгээнүүдээс (хоол хүнс, угаалга ба бусад үйлчилгээ) ихэвчлэн хамааралтай болдог.

Монгол улсын хүн ам цөөн, таруу суурьшсан байдал,¹⁸ уурхай дагасан бүлэглэл үүсч байсан туршлагагүй мөн Оюу Толгой төслийн барилгын ажилд харьцангуй хязгаарлагдмал тооны орон нутгийн ажилчид оролцож байгаа зэрэг нь эдгээр том улс орнуудын туршлагатай харьцуулбал хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй бага төвшинд явагдах төлөвийг илтгэж байна. Дээрх шалтгааны улмаас Монгол улсын хувьд барилгын ажлын үед бага хэмжээний илтгэлцүүрийг ашиглах нь зохимжтой боловч хүн амын бодит шилжилт хөдөлгөөнд тогтмол хяналт мониторинг хийж, зохистой хариу арга хэмжээг авах болно.

Оюу Толгойн барилгын ажлын үе дахь хүн амын шилжин ирэх хөдөлгөөний тооцоолол хийхэд ашиглагдсан үндсэн таамаглалуудыг доор тусгав:

- Барилгын ажлын үеийн хүн амын шилжилт хөдөлгөөний ихэнх нь гэр бүлээр шилжин ирэгсэд биш, харин ганц бие хүмүүсээс бүрдэнэ – одоог хүртэл өрнөсөн хүн амын шилжилт хөдөлгөөний ажиглалтын төлөв байдал дээр үндэслэв,
- Барилгын ажлын үеийн шилжин ирэх хүн амын тоо нь Оюу Толгойн барилгын ажлын ажиллах хүчний хэмжээнээс шууд хамааралтай – ажиллах хүч их байх тусам шилжин ирж болзошгүй хүн амын урсгал, тоо их байна,
- Барилгын ажлын үеийн шилжин ирэх хүн амын хэлбэлзэл нь Оюу Толгойн уурхай дахь ажилд авах, ажлаас халах үйл ажиллагаанаас хамааралтай, тухайлбал: ажил олголтын үеэр шилжин ирэгсдийн тоо өсөх бөгөөд цомхтголын үеэр энэ тоо буурдаг,
- Барилгын ажлын үеийн шилжин ирсэн хүмүүсийн тодорхой хувь нь тухайн газар нутагт сууршин байнгын иргэн болно,
- Өмнөговийн замыг 2010 – 2012 оны хооронд сайжруулах төлөвтэй боловч төслийн талбайн ойролцоо хүнд даацын хурдны зам барьж төсөлтэй холбох ажил хийгдэнэ хэмээн хүлээхгүй байна. Тухайлбал: Оюу Толгой болон Улаанбаатарыг холбосон хурдны зам баригдахгүй.¹⁹

¹⁸ Барклей энд Ассосиаатэс 2007 он. Оюу Толгой: Хүн амын шилжин ирэх хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ. Айвенхоу Майнз Монголиа Инк болон Рио Тинто-д зориулсан суурь судалгааны тайлан.

¹⁹ Энэхүү таамаглал нь Дэлхийн банкний тогтвортой хөгжлийн суурь: Монгол улсад дэд бүтцийн үйлчилгээний хангамжийг эргэн харах тухай (2007 оны 6-р сар) тайланд тусгасан Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагаа болон засвар үйлчилгээнд зориулсан төсөв нь шинэ зам барих төдийгүй одоогийн замын чанарыг

- Шилжин ирэх хүн амын тооцооллыг гаргахад ашигласан илтгэлцүүрүүд нь Оюу Толгой төслийн шууд нөлөөллийн бүсрүү уурхайгаас гадуурх гэрээт гүйцэтгэгч болон үйлчилгээ нийлүүлэх бүлэглэл хэлбэрээр шилжин ирэх ажилчдын тоог мөн авч үзсэн. Тухайлбал: Тоёото үйлчилгээний групп, орон сууц барих гэрээт гүйцэтгэгчид, 2010 – 2012 оны хооронд ажиллах бусад ижил төрлийн байгууллагууд,

Дээр дурдсан таамаглалд тусгасны дагуу санал болгосон 0.3 болон 1.0 илтгэлцүүр нь барилгын ажлын оргил үед (2011) хүлээгдэж буй хүн амын шилжин ирэх хөдөлгөөн нь 2200-7500 хүний хооронд хэбэлзэх бөгөөд төслийн талбай дээр ажиллах хүний хамгийн их тоо нь 12 900 байхаас 7400 нь Монгол улсын ажилчид байна (2010 оны сумын хүн амын тооноос хоёр дахин их байна)²⁰

Оюу Толгойн бэлтгэсэн хамгийн сүүлийн үеийн болон албан ёсны мэдээлэлд үндэслэн мэдээллүүд нь Ханбогд суманд шилжин ирэгсдийн (сумруу болон сумаас) хамгийн бодит мэдээлэл өгнө.

Хүснэгт 8.4: Ханбогд сумруу шилжих хүн амын цэвэр шилжилт (Оюу Толгойн ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг тооцоогүй болно)

| Он | Сумын хүн ам | Шилжин ирэгсэд | Шилжигсэд | Цэвэр шилжилт | Шилжилтийн өсөлтийн хувь |
|------------------------|---------------------|----------------|-----------|---------------|--------------------------|
| 2006 | 2,901 | 183 | 33 | 150 | 5.2% |
| 2007 | 2,974 | 126 | 72 | 54 | 1.8% |
| 2008 | 3,022 | 71 | 68 | 3 | 0.1% |
| 2009 | 3,154 | 96 | 50 | 46 | 1.5% |
| 2010 | 3,522 | 305 | 49 | 256 | 7.3% |
| 2011 (10-р сар хүртэл) | ойролцоогоор. 3,900 | 323 | 86 | 237 | 7.3% (жилээр) |

Эх сурвалж: Оюу Толгойн Ханбогд сумын статистикийн газраас авсан мэдээлэл

Дээрх хүснэгтээс харахад барилгын ажлын үе дэхь шилжин ирэгсдийн цэвэр тоо нь анх таамагласнаас бага байгааг илтгэж байна.

Уурхайн үйл ажиллагааны үед төслийн нөлөөллийн бүс, ялангуяа Ханбогд суманд шилжин ирэх хөдөлгөөний хурд аажмаар удаашрах хандлагатай, учир нь барилгын ажил дуусах үед ажилчдын тоо хэмжээнд эрс бууралт үүсэхтэй холбоотой (ажиллах хүчний нийт бууралт 1-2 жилийн хугацаанд 70% орчимд хүрнэ). Монгол ажилчдын тоог уурхайн үндсэн үйл ажиллагааны үед 3500-д барих болно. Ажиллах хүчний хэрэгцээнд ихээхэн бууралт гарах боловч төслийн нөлөөллийн бүс дэхь бизнесийн таатай орчин, Оюу Толгой мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдтэй холбоотой мэргэжил чадвар дээшлүүлэх боломж, Ханбогд суманд байрлах Оюу Толгойн орон сууц болон дэд бүтцийн хөгжил зэргээс хамаарч хүн амын шилжин ирэх урсгал үргэлжилсээр байх болно (эдийн засгийн хөгжил, ажлын байр бий болох, бизнесийн хөгжлийн боломжуудын талаархи мэдээллийг бүлэг С7: Эдийн засгийн нөлөөлөл болон бүлэг С9: Ажил эрхлэлт-с үзэх). Монгол улсаас 3000-3500 ажиллах хүч авах төлөвлөгөөн дээр үндэслэн уурхайн үйл ажиллагааны эхний жил дэх нийт хүн амын шилжин ирэх хөдөлгөөн нь 900-3500 хооронд хэлбэлзэнэ.

Хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй нөлөөллүүд

Нөлөөллийн тодорхойлолт

Энэхүү хэсэгт 2007 оны Оюу Толгой төсөлд хэрэгжсэн Хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээний дүгнэлтүүдийг оруулсан бөгөөд төсөл 2011 оны 6-р сарын 1-ний өдөр хүртэл үргэлжлэх хугацаанд тохиолдож болзошгүй нөлөөллүүдийг тус тус тусгав.

хадгалан засвар үйлчилгээ үзүүлэхэд туйлын хангалтгүй хэмээн дүгнэсэн дүгнэлттэй тохироно. Тайлан нь хэрэгцээний тухай урьдчилсан тооцоонд тулгуурлаагүй том хэмжээний шинэ замуудын сүлжээ байгуулах хэтэрхий амбицтай төлөвлөгөөнд шүүмжлэлтэй хандсан. Ялангуяа, Орос улсаас Хятад улс хүртэлх буюу Монгол улсны хойд зүгээс урд зүг хүртэлх сунаж тогтсон хурдны зам барих Мянганы замын төсөлд шүүмжлэлтэй хандсан.

²⁰ Бүлэг С9: Хөдөлмөр эрхлэлт-ээс Төслийн ажиллах хүчний тооцооны талаарх дэлгэрэнгүйг үзнэ үү.

2007 оны хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ

Оюу Толгой төсөл нь 2007 онд барилгын ажлын үе шатан дахь Хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээг хийсэн ба энэ нь барилгын ажлын үе шатан дахь шилжин ирэх хүн амын хамрах хүрээ, шинж чанарыг тодорхойлох зорилготой байв.^{21,22} Энэхүү судалгаагаар Оюу Толгой төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөн нь орон нутгийн хүн амд сөрөг болон эерэг нөлөөлөл аль алиныг үзүүлнэ.

Оюу Толгой төслөөс үүдэлтэй хүн амын шилжих хөдөлгөөний болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тусгав. Үүнд:

- Хүн ам шилжин суурьшилттай нэгэн зэрэг эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль дэг журам, газар ашиглалтын зөрчил болон байгаль орчны эрсдлүүд гарах,
- Шилжин ирсэн хүн амын хэрэгцээ, тухайлбал газар, хөлсний байр, хоол хүнс болон бусад шаардлагатай бараа үйлчилгээний эрэлт нэмэгдснээр амьдралын өртөг нэмэгдэх (амьдралын өртөг нэмэгдэх нөлөөтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг С7: Эдийн засгийн нөлөөлөл хэсгээс үзэх),
- Газар, бэлчээр, ус, түлээ зэх мэт байгалийн нөөцийн төлөөх өрсөлдөөн нэмэгдэх,
- Цахилгаан эрчим хүч, халаалт, ус, тээвэр, эмнэлгийн үйлчилгээ, боловсролын байгууламж, болон хязгаарлагдмал дэд бүтэцэд өсөн нэмэгдэж буй хүн амын ачаалал зэргээс шалтгаалан дэд бүтэц болон байгууламжуудын эрэлт хэрэгцээ нэмэгдэх,
- Нийгмийн сөрөг үзэгдлүүд, эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэл, тухайлбал архи согтууруулах бодисны хэрэглээ, биеэ үнэлэлт, мөрийтэй тоглоом, болон халдварт өвчин дэлгэрэх эрсдэл нэмэгдэнэ (үүнд бэлгийн замын халдварт өвчин БЗХТ болон ДОХ орно).
- Хууль дүрэм зөрчих явдал гарах, тухайлбал гэмт хэрэг болон хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх,
- Орон нутгийн удирдлагын орлогын урсгал нэмэгдсэнтэй холбоотой үүсэх удирдлагын эрсдлүүд гарч болзошгүй тухайлбал үүнд хангалтгүй хяналт тавигдах, орлогыг түгээх журамд хангалтгүй хяналт тавих, газар хувиарлалт, шинээр ирэгсдийн бүртгэл болон боломжит ажлын байраар хангах ажлыг түргэвчлүүлэх зорилгоор орон нутгийн захиргааны ажилтнуудад албан бус төлбөр өгөх явдал дэлгэрэх асуудлууд орно.
- Нийгмийн зөрчил хурцдах эрсдэл, үүнд нутгийн иргэд ба шилжин ирэгсдийн хооронд гарах зөрчил эсвэл баялгийн тэгш бус, тогтворгүй хувиарлалтанд хүргэсэн эдийн засгийн ялгаатай нөлөөллүүдийн талаарх орон нутгийн иргэд хоорондын зөрчил, тухайлбал зарим иргэд үр ашиг хүртэж байхад нөгөө хэсэг нь эмзэг байдалд орох гэх мэт,
- Нийгмийн задрал, үүнд үндэсний уламжлалт дээдэлдэг үнэт зүйлсээ алдах, нийгмийн аюулгүй байдлын сүлжээ сарних, аюулгүй байдал доройтох асуудлууд гарч эдгээр нь эргээд нийгмийн сөрөг хандлагыг дуудах. Үүнд: архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт болон хосууд салах багтана.

2007 оны хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдийн үнэлгээнд Оюу Толгой төсөлтэй холбоотой үүсэх хүн амын шилжилт хөдөлгөөн нь дараах эерэг нөлөөлөлд хүргэж болно хэмээн үзсэн. Үүнд:

- Хөдөө тосгоноос гарах хүн амын шилжих хөдөлгөөнд эсрэг нөлөө үзүүлэх, тухайлбал бүсийн төв болон хот руу өмнө нь шилжихийг илүүд үзэж байсан илүү боловсрол мэдлэгтэй хувиара бизнес эрхлэгч хувь хүмүүс эргэн ирэх,
- Орон нутгийн иргэдэд зориулсан илүү олон төрлийн, чанар сайтай бараа үйлчилгээний хангамж үүсэх бөгөөд зарим тохиолдолд үнэ нь зах зээлийн өрсөлдөөний зарчмаар тогтоогдоно.

²¹ Оюу Толгой: Хүн амын шилжих хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ, Айвенхоу Майнз ба Рио Тинто, Барклэй энд Ассоциатэс, 2007 оны 10-р сар.

²² Барилгын ажлын үе дэх эрсдийн үнэлгээ нь голчлон Оюу Толгойн эргэн тойронд 2007 оны ажилын хязгаарлагдмал хүрээнд өрнөсөн хүн амын шилжилт хөдөлгөөн дээр төвлөрсөн бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийг ашиглан ирээдүйн боломжит үзэгдлүүдийг урьдчилан тооцоолсон.

- Төсөлд шууд ажилд орсноор болон шууд бус байдлаар ажил эрхлэх боломж үүсч, цалингын өсөлт болон орлогын урсгалын үр дүнд (холбогдох хувийн хэвшил, бизнесийн сектор) орон нутгийн эдийн засаг сайжиран үүний үр дүнд орон нутгийн худалдан авах чадвар сайжирна.
- Бизнесийн боломжууд нээгдэж өрсөлдөөний дүнд сайжирна,
- Алслагдсан ард иргэдийн хувьд гадаад зах зээл болон дэлхий ертөнцтэй холбоо тогтоох, мэдээлэл солилцох боломж нээлттэй болно.

Хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөллийн сүүлийн үеийн шинэчлэгдсэн мэдээлэл

Энэхүү хэсэгт төслөөс шалтгаалан Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс нутаг руу шилжин ирэх хүн амын шилжих хөдөлгөөний нөлөөллийн талаарх илүү дэлгэрэнгүй шинэ мэдээллүүдийг тусгав.

Бэлчээрийн даацанд учруулах ачаалал

Ханбогд сум руу шилжин ирэх хүн амын дийлэнх хувь нь Оюу Толгой ХХК-д шууд болон ханган нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан шууд бус ажилд горилсон хотын, мэргэжилтэй эсвэл хагас-мэргэжилтэй, эсвэл хар ажилчид байна²³. Шинээр шилжин ирэгсэд нүүхдээ орон нутгийн удирдлагад бүртгэл хийлгэх, маш хол зай зэргийг харгалзан үзвэл Ханбогд сумруу шилжин ирэх малчдын (болон малын тоо) тоо тийм ч их байхгүй юм. Гэвч, одоогийн Ханбогд сумын малчдын орлого нэмэгдснээр тэдгээрийн одоогийн малын тоо толгой өсч, улмаар бэлчээрийн даац хэтрэх тохиолдол илэрэх боломжтой (илүү дэлгэрэнгүй мэдээллийг *Бүлэг В10: Газар ашиглалт болон Бүлэг С10: Газар ашиглалт ба шилжилт хөдөлгөөн хэсгээс* үзнэ үү).

Биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх ачаалал болон байгаль орчны доройтол

Биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлж болох нөлөөлөл болон бэлчээрийн даацад ачаалал учрахтай холбоотой үүсэх байгаль орчны доройтол, зэрлэг амьтадтай үүсэх өрсөлдөөн ба хууль бус ан агнуурын талаар *Бүлэг С6: Биологийн төрөл зүйлийн олон янз байдал хэсэгт* авч үзсэн.

Эдгээр асуудлуудыг Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нэмэлт тодотголд авч үзэх бөгөөд үүнд ажилчдын орон сууц барих, мөн холбогдох дэд бүтэцийн байгууламжууд барих болон Ханбогд сумын төвийн хүн амтай холбоотой үүсэх тодорхой нөлөөллүүдийг хэлэлцэнэ.

Нийтийн байгууламж болон үйлчилгээнд учрах ачаалал

Нийтийн байгууламж болон үйлчилгээ ашиглахтай холбоотой үүсэх нөлөөллийн түвшин болон онцлогыг эрэлт, нийлүүлэлтийн үндсэн дээр тогтооно. Тухайлбал:

- Нийлүүлэлт – нийгмийн дэд бүтэц болон байгууламжид зориулан аймаг болон сумын удирдлагад Монгол улсын Засгийн газраас хувиарласан төсөв, хөгжил дэмжсэн агентлагууд болон томоохон төсөл хэрэгжүүлэгчдийн үзүүлсэн туслалцаа дэмжлэгийг ойлгоно.
- Эрэлт- их хэмжээгээр өссөн хүн амын түвшин, хүн амзүйн өөр өөр бүтэц, насны бүтцийн өөрчлөлт зэрэг нь зарим тодорхой төрлийн байгууламж болон үйлчилгээний хэрэгцээг авчирч, хэт ачааллыг бий болгоно(тухайлбал боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээ).

Төслийн нөлөөллийн бүс дэх нийгмийн дэд бүтэц нь цөөн хүн ам болон тархай бутархай сууршсан байдалтай холбоотойгоор хөгжил муутай, хязгаарлагдмал түвшинд байдаг. Хотын үйлчилгээний гүйцэтгэлийн чанар харилцан адилгүй ба ерөнхийдөө хүртээмж муу, үйлчилгээ хангалтгүй, чанарын хувьд дутагдалтай. (орон нутгийн иргэдэд үзүүлэх үйлчилгээ болон дэд бүтцийн өнөөгийн бодит байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Бүлэг В11: Тээвэр ба дэд бүтэц хэсгээс* үзнэ үү)

Эрчим хүч нийлүүлэлт

Хүн амын шилжилт хөдөлгөөн нь Ханбогд сум болоод төслийн нөлөөллийн бүсийн Даланзадгад хот болон бусад сумдын **өнөөгийн эрчим хүчний хангамж болон эрчим хүчний дэд бүтцэд үзүүлэх ачааллыг ихэсгэнэ**. Төслийн нөлөөллийн бүст хамаарагдах олон айл өрхийн ихэнх нь нүүдлийн ахуйгаар гэрт амьдардаг учир төвлөрсөн суурин цахилгаан хангамжийн сүлжээнээс

²³ Энэ нь 1970-аад оны үед Эрдэнэт уурхайд тохиолдсон бөгөөд мөн Энержи Ресурс ХХК-н одоогийн Цогтцэций сумын уурхайн үйл ажиллагаанд мөн илэрсэн.

хамааралтай байх нөхцөл харьцангуй хязгаарлагдмал тул олонхи айл өрх бүр тус тусдаа өөрсдийн хэрэгцээг хангах бололцоотой. Гэвч, төслийн бүс нутагруу гаднаас шилжин ирэгсэд төвлөрсөн эрчим хүчний сүлжээтэй Ханбогд сум болон аймгийн төв Даланзадгад хотруу төвлөрөх хандлагатай байна. Үүний үр дүнд төвөөс түгээх эрчим хүчний хэрэгцээ ялангуяа эдгээр газруудад нэмэгдэх хандлагатай байна. Цаашилбал, Ханбогд сумын төв одоогийн байдлаар өртөг өндөртэй дизель хөдөлгүүрт эх үүсвэрээс хараат байдаг ба уг сум ирээдүйн хөгжлөө хангахын тулд эрчим хүчний хямд эх үүсвэрт зайлшгүй шилжих шаардлагатай (Оюу Толгой төслийн өндөр хүчдэлтэй холбогдох замаар).

Усан хангамж

Бүлэг В11: Тээвэр ба дэд бүтэц-т дурдсанчлан Ханбогд сумын ард иргэд одоогийн байдлаар нөөцийн ус, жижиг шахуурга бүхий нийтийн худгуудаас усны хэрэгцээгээ хангадаг бөгөөд сумын төвийн хүн амын зөвхөн 1 хувь нь усан хангамжийн шугамд холбогдсон. Харин Ханбогд сумын хөдөөгийн газар нутагт төвийн усан хангамжинд холбогдох бололцоо байдаггүй. Хүн амын зөвхөн тал хувь нь (56%) хамгаалагдсан худгаас усаа авдаг бол үлдсэн 43% нь хамгаалалтгүй худгаас авдаг.

Оюу Толгой төслийн улмаас нутгийн ард иргэдийн усан хангамжинд нөлөө үзүүлэх 3 үндсэн асуудал байна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд зориулсан усан хангамж,
- Ханбогд сумын хүн амд зориулсан усан хангамж (одоогийн хүн ам болон шилжилт хөдөлгөөний үр дүнд өсөн нэмэгдэх хүн амыг тооцоход)
- Хөдөөгийн хүн амын усан хангамж ялангуяа малчдын усан хангамж тасалдах

Барилгын үе шатанд Оюу Толгой төсөл нь үйлдвэрлэлийн болон ундны хэрэглээний зорилгоор ашиглах усны хэрэгцээгээ УЛТ доторх бага гүний уст давхрагын цооногуудаас татаж хангана. Энэхүү цооногуудыг хэрэглэх бусад хэрэглэгч байхгүй учир тус ус татаж ашиглах явдал нь талбайгаас гадна орших малчдын худаг болон бусад ус хэрэглэгчдэд нөлөө үзүүлэхгүй юм. Барилгын ажлын шатанд Ундайн сайрын гадаргын болон гадаргын доорхи усны урсацыг өөрчлөх систем байгуулагдах бөгөөд ингэснээр урсацыг уурхайн ил амыг тойруулан урсгаж УЛТн гаднах урсгал доорхи хэсэгтэй нийлүүлэх юм. Энэ нь УЛТ дотор орших Бор Овоо булагт шууд нөлөөтэй ба үүнээс малчид, зэрлэг амьтад ундаалдаг (*Бүлэг С5: Усны нөөц*-өөс төслийн үйл ажиллагаанаас малчдын усан хангамжид нөлөөлөх нөлөөлөл, үйлдвэрлэлийн шатанд тогтвортой усан хангамжаар хангах асуудал мөн Оюу Толгой төслөөс малчдын худгийг усан хангамжтай байлгах мөн Ханбогд сумын хөгжлийг тэтгэх талаар авах арга хэмжээний талаархи дэлгэрэнгүйг үзнэ үү).

Ханбогд сумын иргэдийн усан хангамж нь ганц нэг худаг эсвэл нийтийн худгаас орон нутаг дахь бага гүний уст давхрагаас ус шавхаж гаргадаг ус хангамжийн сүлжээ системд шилжих төлөвтэй байна. Мөн усны эрэлт хэрэгцээ нь хүн амын тоо өсч эдийн засаг идэвхжихийн хэрээр өсөн нэмэгдэх болно. Энэ нь тухайн бүс нутгий гүний усны нөөцийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх болно.

Оюу Толгой төсөл нь Усны Газар ба Ханбогд сумын удирдлага болон бусад байгууллагуудтай Ханбогд сумыг усаар хангах өөр эх үүсвэрийг тодорхойлох, ашиглах тал дээр хамтран ажиллаж байна²⁴. Ус хангамжийн хамгийн тохиромжтой цооногийн байршлыг тодорхойлох явдал Оюу Толгой төслийн хувьд үргэлжилсээх байгаа судалгаа ба энэ ажлын хүрээнд 3 цооногийг Ханбогд сумын төвөөс зүүн хойд зүгт ойролцоогоор 6 км зайд өрөмдсөн ба энэ нь ундны усанд хэрэглэж болохуйц томоохон гүний усны нөөц буйг харуулсан (В 6.10 хэсгийг үзнэ үү). Энэхүү усны нөөцийг агуулж буй сав газар нь сумын төвийн урд байх Ханбогд масств болон хойно байрлах Дөрөлж уулын суурь чулуулгаас ирэх гүний урсац ба хур тунадаснаас тэжээгддэг хэмээн үзэж байна. Оюу Толгой төсөл нь одоогийн байдлаар тус нөөцийг тодорхойлж Усны Газарт тооцоолсон нөөцийн хэмжээг хэлэлцүүлж байна. Оюу Толгой төсөл нь мөн Усны Газар, Ханбогд сумын Засаг Дарга, Азийн Хөгжлийн Банк болон бусад байгууллагуудтай хамтран усны түгээлтийн системийн төлөвлөлтийн ажилд туслалцаа үзүүлж байна. Сумын усаар хангах системийг хэрэгжүүлэх эхний шатанд усыг 30 л/сек хурдтайгаар дамжуулахаар төлөвлөсөн ба энэ нь ирээдүйд Ханбогд сум хөгжиж хүн ам

²⁴ Энэ нь Оюу Толгой төслийн үйл ажиллагааны улмаас шууд нөлөөлөлд өртөж буй орон нутгийн сумын төвд найдвартай аюулгүй ундны усаар хангах тухай Засгийн Газрын үүрэг хариуцлагад тусламж дэмжлэг үзүүлэх тухай үүргийг илэрхийлж байна – Хөрөнгө Оруулалтын Гэрээ (2009) Зүйл 6.15

шилжин ирэхийн хэрээр хүчин чадалаа нэмэгдүүлэх боломжтой байх юм. Усан хангамжийн асуудлын зэрэгцээ бохир ус цэвэрлэх байгууламжийг давхар шийдэх бөгөөд үүгээр усыг цэвэрлэсний дараа дахин ашиглахыг зорих бөгөөд энэ талаар ажил одоогоор төлөвлөлтийн шатанд байна.

Уг асуудлыг *Бүлэг С5: Усны нөөц* хэсэгт илүү дэлгэрэнгүй авч үзсэн. Үүнийг Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотголд тусгах ба үүнд Ханбогд сумын усан хангамж ба Оюу Толгойн ажилчдын суурингийн усан хангамжийн талаар авч үзнэ.

Бохир ус зайлуулах шугам хоолойн систем болон ариун цэвэр

Төслөөс шалтгаалсан шилжилт хөдөлгөөний дүнд үүссэн Ханбогд сумын хүн амын өсөлт нь одоогийн ариун цэврийн хангалтгүй дэд бүтцэд ачаалал үзүүлнэ. Одоогийн байдлаар Ханбогд суманд бохирын төвлөрсөн систем байхгүй бөгөөд ийм чухал байхгүй байдал болон зохистой жорлонгийн систем дутагдсны улмаас албан бус нүүдлийн суурингуудад ялангуяа, иргэд тоноглогдоогүй, ариун цэврийн шаардлага хангаагүй түр зуурын шийдлүүдийг хэрэглэх хандлагатай болдог. Энэ нь халдварт өвчин тархах орчин орчин бүрдүүлэх хүчин зүйл болно. Нүхэн жорлонг ашиглах явдал ихсэх нь сумын төвийн болон бусад суурингуудын худгийн ундны усыг нянгаар бохирдуулах явдлыг өдөөх боломжтой. Хотын төвд хүн ам төвлөрөх мөн олон давхар барилга барих зэрэг нь бохир ус зайлуулах шугам хоолойн систем болон хаягдал ус цэвэрлэх байгууламж барих шаардлагыг гарган ирж байна.

Хатуу хог хаягдал

Одоогийн байдлаар төслийн нөлөөллийн бүс нутаг дахь дөрвөн сумуудад (Ханбогд, Баян Овоо, Манлай, Даланзадгад) хязгаарлагдмал хэмжээний хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээ бий. Ханбогд сумын төвд дунд зэргийн хаягдал цуглуулах төв байдаг бөгөөд хаягдлыг хагас хашлагатай ил хог асгах цэгт хаядаг²⁵. Хүн амын шилжилт хөдөлгөөний үр дүнд үүсэх орон нутгийн хүн амын өсөлт нь төслийн талбай дахь одоогийн сул хөгжилтэй байгаа хог хаягдлын системийн дэд бүтцийн ачааллыг нэмэгдүүлнэ (Бүлэг D8: Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг үзнэ үү) .

Оюу Толгойн үйлчилгээг хариуцсан CIS компаниас ялгарч буй хатуу хог хаягдлыг УЛТ доторхи хог хаягдлын менежментийн цэгт одоогийн байдлаар хаяж зайлуулж байна.

Хог хаягдлын менежментэд тулгарах өссөн дарамтыг шийдвэрлэхийн тулд Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэйгээр хог хаягдлыг дарж булж устгах зориулалтын цэгийг байгуулахаар төлөвлөгдсөн.

Эмнэлгийн үйлчилгээ, байгууламж

Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд Оюу Толгой төсөл хэрэгжсэнээр нөхөн үржихүйн насныхан хүн амын өсөлтөнд хүргэж, улмаар төслийн нөлөөллийн бүс дэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн төвүүд ба гэр бүлийн зөвлөгөө өгөх төвүүдийн ачааллыг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Мөн бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) эрчүүд давамгайлсан олон тооны ажиллах хүч болон уурхай дагасан тосгонуудад дэлгэрч болзошгүй биеэ үнэлэх үзэгдлээс шалтгаалж БЗХӨ ихсэх магадлалтай.

Төсөлтэй холбоотойгоор хүн амын шилжин ирэх хөдөлгөөний тооцоогоор төслийн барилгын ажлын үед Ханбогд болон Даланзадгад сумуудад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нэмэлт боловсон хүчин шаардлагатай болохыг харуулж байна. Оюу Толгой нь энэхүү өсөн нэмэгдэх хэрэгцээг хэрхэн өндөр түвшинд хангахын талаар орон нутгийн засаг захиргаатай хэлэлцэж, олон төрлийн эрүүл мэндийн үйлчилгээний санал санаачлагуудыг хэрэгжүүлж байна. Тухайлбал: Өмнөговь аймагт ирж ажиллах 14 мэргэшсэн доктор урьж авчирсан эрүүл мэндийн тэтгэлэгт хөтөлбөр, Ханбогд суман дахь шүдний эмнэлэг байгуулах, аймгийн хэмжээнд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвүүд байгуулах мөн Жавхланта багийн төвд гэмтлийн төв байгуулах зэрэг багтана.²⁶ Хүн амын өсөлт болон хүн амын насны бүтцийн өөрчлөлтийн үр дүнд эмнэлгийн тодорхой үйлчилгээнүүдийн эрэлт нэмэгдэж, том ослын үе дэх түргэн тусламжийн ачааллыг нэмэгдүүлнэ. (Эрүүл мэндэд

²⁵ Оюу Толгой төслийн нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ эцсийн тайлан, 2009 оны 9-р сар. Бодлого судлалын төв, Хүн амын сургалт судалгааны төв, МУИС-ийн Эдийн засгийн сургууль.

²⁶ Оюу Толгой төслийн Орон нутгийн иргэдийн мэнд, Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх тэнгэр хөгжил консерциум, (ХТХК, 2011 он), (ХТХК-ын 2010 онд явуулсан хэргийн судалгаа).

үзүүлэх нөлөөлөл, халдварт өвчний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бүлэг В 13: Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгааллын тухай хэсгээс үзнэ үү)

Боловсролын үйлчилгээ

Боловсролын үйлчилгээ болон сургуулиудад ачаалал үүсгэх тухайлбал сургуулиас өмнөх насны хүүхдийн байгууламж (цэцэрлэг, ясли) болон сургууль – сургуулийн тоо болон хүүхэд хүлээн авах хүчин чадал, заах багш нарын хүрэлцээ (багш нар/сурагчдын харьцаа) болон тоног төхөөрөмжинд үзүүлэх ачаалал нэмэгдснээр боловсролын хүртээмж, ерөнхий чанар, боловсрол эзэмших түвшин зэрэгт нөлөөлж, урт болон дунд хугацааны турш Оюу Толгой төсөл орон нутгаас зохих боловсролтой ажиллах хүч ажилд авах боломжинд нөлөөлнө. Суурь судалгаанаас үзэхэд тус нутагт чадвартай багш, сурган хүмүүжүүлэгч, ном товхимлын хангалт, сургуулийн барилгын дутагдалтай байдаг ажээ. Төслийн нөлөөллийн бүс нутаг дахь сургуулиуд нь компьютер хангамжаар тоноглогдсон боловч интернэт хангамж байхгүй ба эрчим хүчний хангамжийн асуудал найдваргүй байдаг ажээ²⁷.

Бүсийн хэмжээнд хүн амын насны ерөнхий үзүүлэлтээс харахад төслийн нөлөөллийн бүсэд шилжин ирсэн хүн амын 25% нь сургуулийн насны хүүхдүүд гэж үзвэл Оюу Толгой төслийн барилгын үе шатанд нэмэлт 550-1875 хүүхдийн хүчин чадалтай сургууль шаардлагатай болно. Эдгээр нэмэлт сургуулиудын ихэнх хувь нь шилжин ирэх хүн ам ихээр төвлөрөх Ханбогд болон Даланзадгад сумуудад баригдах шаардлагатай. Сүүлийн үеийн баримтаас үзэхэд Ханбогд суманд шилжин ирэгсэд нь аль хэдийн өсөн нэмэгдсэн сурагчдын тоогоор их хэмжээний дарамт учруулж, төлөвлөгдсөн чадамжаас хол хэтэрсэн тус сумын боловсролын үйлчилгээний нөөцөд ачаалал үзүүлж байгаа ажээ²⁸.

Ерөнхийдөө, хүн амын шилжин ирэх хөдөлгөөн нь, төслийн нөлөөллийн бүсийн өнөөгийн сул дэд бүтэц болон хангалтгүй үйлчилгээний чадамжтай хослон дараах болзошгүй асуудлуудыг үүсгэнэ:

- Шилжин ирсэн хүн амын үзүүлэх нэмэлт ачаалал болон эрэлт хэрэгцээний улмаас орон нутгийн иргэдийн одоогийн байдлыг улам доройтуулна,
- Байгалийн хязгаарлагдмал нөөц, хүрэлцээ муутай нийгмийн үйлчилгээний төлөөх өрсөлдөөнийг хурцатгаж, зөрчилдөөн болон хагарал үүсэх нөхцлийг бүрдүүлнэ.

Чухал дэд бүтэц болон үндсэн үйлчилгээний одоогийн хомсдол нь хүн амын шилжин ирэх хөдөлгөөний үр дүнд улам нэмэгдэх ба улмаар амжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдал ялангуяа хувь хүн ба орон нутгийн иргэдийн ирээдүйд итгэх итгэлийг бууруулна.

Ниймгийн дэд бүтэц болон үйлчилгээг сайжруулан тэлж, тэдгээрийн чадамж, чанарыг нэмэгдүүлэх нь төсөлтэй холбоотойгоор гарах хүн амын шилжилт хөдөлгөөн, хүн амын огцом өөрчлөлттэй амжилттай дасан зохицоход чухал юм. Энэхүү ажлыг гүйцэтгэхийн тулд мөн хэрэгцээтэй зохих хүчин чадал бүхий найдвартай дэд бүтэцийн бүрэлдэхүүн хэсгүүд болон нэн шаардлагатай үйлчилгээнүүдээр төслийн нөлөөллийн бүс дэх өсөн нэмэгдэж буй хүн амыг хангах явдлыг хангахын тулд тал талын оролцоог тухайлбал Оюу Толгой төсөл, Засгийн Газрын байгууллагууд ба бусад холбогдох оролцогч талуудын урьдчилсан төлөвлөлт болон хамтын ажиллагааг шаардана.

Эдгээр асуудлуудыг Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотголд тусгах бөгөөд уг үнэлгээнд Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор Ханбогд сумын төвийн нийтийн хэрэгцээний дэд бүтэц болон үйлчилгээнд ачаалал үүсгэх явдлыг авч үзнэ.

Инфляцийн улмаас үүсэх ачаалал

Ханбогд сумын хэмжээнд орон нутгийн эд барааны үнэ болон амьжиргааны өртөг Оюу Толгой төслийн барилгын ажлын шатанд ерөнхийдөө өснө хэмээн хүлээж байна. Сумын хэмжээнд хэрэглэгчдийн худалдан авдаг барааны үнэд инфляци үүсч эхэлсэн эсэхийг илтгэх мэдээ байхгүй

²⁷ Боловсролын байгууллага болон түүнтэй холбоотой хүндрэл бэрхшээлийн талаарх дэлгэрэнгүйг Бүлэг В13: Тээвэрлэлт болон дэд бүтэц бүлгээс үзнэ үү.

²⁸ Ханбогд сумын орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй уулзсан уулзалт ярилцлага, 2010 оны 9-р сар.

боловч Монгол улс даяар хэрэглээний барааны үнийн инфляци бүртгэгдсэн байна²⁹. Амжиргааны өртөг өсөх болон үнийн инфляцийг үүсгэх гол хүчин зүйлст доорхи багтана:

- Тус бүс нутагт хэрэгжих Оюу Толгой ХХК болон бусад төслүүдийн үйл ажиллагаатай холбоотойгоор орон нутагт зарцуулах зарлага нэмэгдэх
- Нутгийн иргэд амь зуулга залгуулах хэлбэрээр цалинтай ажил эрхлэх хэлбэрт шилжсэнээр зарцуулах чадвар нэмэгдэх, түүнчлэн
- Нутгийн иргэд хадгаламж үүсгэх мөн зээл авах боломжтой болох зэрэг юм.

Орон нутгийн бизнес өсөж буй эрэлт хэрэгцээг зохих хэмжээгээр хангаж чадахуйц болтлоо өсөх хүртэл хангалтгүй байгаа нөөц болон үйлчилгээний төлөөх өрсөлдөөний улмаас орон нутаг дахь үнийг өсгөх болно. Сум руу шилжин ирэх төлөвтэй байгаа хүмүүсийн нөлөөгөөр өсөн нэмэгдэх хүн амын эд бараа болон үйлчилгээний эрэлт хэрэгцээний улмаас энэ хандлага улам хурцадна. Үүнээс гадна хөгжил муутай орон нутгийн зах зээл нь зарцуулах чадвараар харьцангуй илүү, орлоготой хүн ам (ялангуяа уул уурхайн салбарын ажилчид болон гадаадын ажилчид) нэмэгдэхийн хэрээр үнэ өсч инфляци үүсгэх магадлалтай. Энэ нөлөөлөл нь орон сууц, хүнсний бүтээгдэхүүн, гадуур хооллох, тээврийн үйлчилгээ, эмнэлгийн үйлчилгээ, амралт чөлөө цаг зэрэг бараа үйлчилгээний өссөөр байгаа үнэд зохицох чадамжаар илүү олон тооны хүмүүсийн улмаас үүснэ.

Үнийн өсөлт нь эргээд амьжиргааны нийт өртөгийг тухайлбал хэрэглээний үнэ, түрээс, хүнсний бараа, тээвэр болон инфляцитай шууд холбоотой хэрэглээний үнийг өсгөх болно. Оюу Толгой төсөл болон хэрэгжиж буй эсвэл төлөвлөлтийн шатанд яваа бусад томоохон төслүүдийн улмаас бүсийн хэмжээнд мөн орон нутагт амжиргааны өртөг өсөх төлөвтэй байна (*Бүлэг С13 Хуримтлагдах нөлөөллийг үзнэ үү*).

Амжиргааны өртөг өсөх болон үнийн ерөнхий өсөлтийн үр нөлөөг орон нутгийн иргэд янз бүрээр тусгах болно. 2011 оны 6-р сарын байдлаар Ханбогд сумын хэмжээнд 15 өрхийн 73 хүн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт эмзэг хэмээн бүртгэгджээ³⁰. Инфляцийн нөлөөнд дасан зохицох чадвар орлого нь тогтмол (төрийн албаны ажилчид) болон өөрчлөгдөн буй эдийн засгийн нөхцөл байдалд дасан зохицох боломжгүй хүмүүсийн хувьд хэцүү болно. Үйлдвэрлэлийн шатанд барилгын шаттай харьцуулахад ажиллах хүчний эрэлт буурах мөн эдийн засгийн хожоо хайн нүүж ирсэн хүмүүс буцах мөн орон нутгийн бизнес сайжрах зэрэг нөлөөгөөр үнэ тогтворжино хэмээн хүлээж байна.

Ханбогд сумын хэмжээнд үнийн өсөлтөөс үүдэлтэй нөлөөлөл болон бэлэн мөнгөнд түшиглэсэн эдийн засгаас хамаарах байдлын талаар *Бүлэг С7: Эдийн засгийн нөлөөлөл*-д авч үзэв. Иймээс тэр бүлэгт тодорхойлсон нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг энэ бүлэгт авч үзсэнгүй. Энэ асуудлыг байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотголд авч үзэх бөгөөд үүнд Ханбогд суманд болон Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор малчдын уламжлалт амьдралын хэв маягт үзүүлэх эдийн засгийн нөлөөллийн талаар тусгана.

Малчдын уламжлалт амьдралын хэв маягт дарамт учрах

Өмнөговьд томоохон уул уурхайн төслүүд хэрэгжсэнээр нүүдлийн мал аж ахуй эрхлэх амьдралын хэлбэрээс цалинтай ажилд шилжих шилжилт явагдах болно. Олон тооны малчид эдгээр компаниудад ажилд орно гэдэг нь тодорхой бөгөөд одоо ч зарим нь ажиллаж байна. Уламжлалт амьдралын хэв маягаа алдах нь биет бус соёлын өвд учрах зайлшгүй сөрөг нөлөө юм. Үүнийг ажил хөдөлмөр эрхлэх тэгш боломжоор хангах мөн уламжлалт ёс заншлыг ажиглах замаар тодорхой хэмжээгээр бууруулж болох юм. Одоогийн байдлаар Оюу Толгой төсөл нь мал маллах ажлынхаа хажуугаар эрхэлж болох ажил эрхлэх боломж олгох замаар орон нутгийн малчдад үзүүлэх дарамтыг зохицуулж байна. Ийм арга хэмжээнд байгаль хамгаалагч/ажиглагчаар ажиллах мөн Оюу Толгой төслийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдэд оролцох гэх мэт багтана.

Уламжлалт амьдралын хэв маягт үзүүлэх дарамтын нөлөө болон Ханбогд сумын хэмжээн дэх бэлэн мөнгөнд түшиглэсэн эдийн засгаас хамааралтай байх явдлын талаар *Бүлэг С11: Соёлын өв*

²⁹ Монгол улсын хэрэглээний үнийн индекс, 2011 оны 6-р сар

³⁰ Ханбогд сумын Хөдөлмөр халамжийн үйлчилгээний төвийн статистик мэдээ, 2011 ОНХТХХ-н тайлан

болон *Бүлэг С7: Эдийн засгийн нөлөөлөл* хэсэгт авч үзэв. Иймээс тухайн бүлгүүдэд дурьдсан бууруулах арга хэмжээнүүдийг энэ бүлэгт авч үзээгүй.

Энэ асуудлыг Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотголд авч үзэх бөгөөд үүнд Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор малчдын уламжлалт амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөллийн талаар авч үзэнэ.

Хүйсийн харьцаа алдагдах

Одоогийн байдлаар Ханбогд сумын төвд амьдарч байгаа Оюу Толгой төслийн ажилчдын олонхи нь орон нутгийн айл өрхийн гишүүд эсвэл Ханбогд сумын төвийн захад байрлах CIS кемпэд ажилладаг эмэгтэй ажилчид юм. Иймээс уурхайн төсөлтэй холбоотой үүсдэг хүйсийн харьцаа алдагдах явдал одоогийн байдлаар үүсээгүй байна (архидалт, хүчирхийлэл, бие үнэлэлт болон бэлгийн дарамт гэх мэт үр дагавар).

Энэ асуудлыг БОННБҮ-ний нэмэлт тодотголд тусгах бөгөөд үүнд ажилчдын орон сууцны тухай асуудлыг тусгана. Ханбогдод байгуулах орон сууцыг гэр бүлтэй ажилчдад зориулан барина хэмээн төлөвлөж байгаа бөгөөд ганц бие ажилчид УЛТ-д кэмп дээр үргэлжлэн байрлах болно. Иймээс хүйсийн харьцаа алдагдах явдал ноцтой асуудал биш хэмээн үзэж байгаа ба үүнийг БОННБҮ-ний нэмэлт тодотголоор баталгаажуулах болно.

Хувь хүний аюулгүй байдал болон эрүүл мэндэд үзүүлэх дарамт

Бүлэг С12: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгааллын талаарх хэсэгт тусгасны дагуу ажилчид болон энгийн иргэд тус бүс нутагт шилжин ирэх хөдөлгөөн, мөн газар-төвтэй уламжлалт амьдралын хэвшилд орох өөрчлөлт нь хувь хүний аюулгүй болон амгалан тайван байдалд дараах нөлөөллүүдийг учруулж болзошгүй:

- Гэмт хэрэг нэмэгдэх,
- Архидалттай холбоотой өвчлөл болон аваар осол нэмэгдэх,
- Цагдаагийн байгууллага болон нийтийн үйлчилгээний салбарын ачаалал нэмэгдэх,
- Малчдын амгалан тайван байдал, эрүүл мэнд алдагдах,
- Хүний наймаа.

Уулзалтын үеэр орон нутгийн иргэдийн хувь хүний аюулгүй байдал орон нутгийн иргэдийн хувьд санаа зовоох асуудал болоод байгаа ба үүнд тус бүс нутагт шилжин ирсэн ажилчид болон энгийн иргэдийн ёс суртахуунгүй үйлдлийн улмаас хувь хүний болон өмчийн аюулгүй байдалд нөлөөлөх нөлөөлөл орно гэдгийг тодорхойлсон.³¹ Өмнө нь Ханбогд болон түүний зэргэлдээх сумдад гэмт хэргийн түвшин бага байсан. Сумын хэмжээнд 2009 ба 2010 оны байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 41, 38 тус тус байсан бол энэхүү нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа гэсэн таамаглал байна.³² Малчид хулгай, хувийн аюулгүй байдал, өмчлөх эрхэд халдсан гэмт хэрэгт эмзэглэж байгаа бөгөөд учир нь өмнө нь хулгайн хэрэг гардаггүй байсан ба малчид өмч хөрөнгөө цоожлох шаардлага гардаггүй байжээ. Харин одоогоор танихгүй хүмүүс ихэсч, тухайлбал: мотоциклтэй залуучууд айлаар хэсэх боломжтой болсон.³³ Өсөн нэмэгдэх гэмт хэргүүдийн нөлөөлөлд амьжиргаа болон өмч хөрөнгөд халдах халдлагууд, хүч хэрэглэх (танхайрах, бэлгийн дарамт) болон хүний эрх чөлөөнд халдсан үйлдлүүд орно. Орон нутгийн иргэдийн үзэж байгаагаар төслийн ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид архидан согтуурч, хулгай зэрэг жижиг гэмт хэрэг үйлдэх боломжтой гэжээ.

Монгол улсын хэмжээнд өнгөрсөн 5 жилд амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотой өвчин эмгэг, осол гэмтлийн тоо нэмэгдсэн байна (гэмтэл, хүчирхийлэлтэй холбоотой, зам тээврийн осол,

³¹ Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, 2009 оны 9-р сар, сүүлийн тайлан. Бодлого Судлалын Төв, Хүн амын сургалт судалгааны төв, МУИС-ийн Эдийн засгийн сургууль, хууд-67.

³² Ханбогд сумын ЗДТГ, 2011 онд Оюу Толгойн авсан мэдээлэл, *Бүлэг В15: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалалт* (суурь нөхцөл) – дурдсан ишлэлийн дагуу.

³³ Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалалтанд нөлөөлөх байдлын үнэлгээ, ХТХК, 2011 он (ХТХК-ын 2010 онд явуулсан хээрийн судалгаа).

архидалттай холбоотой өвчлөл)³⁴. 2007 онд зөвхөн Өмнөговь аймагт эрүүлжүүлэх төвүүдэд 3076 хүн хамрагджээ. Энэ нь өмнөх жилтэй харьцуулахад 16%-иар өссөн үзүүлэлт байна. Аймгийн хувьд (Монгол орны аль ч хэсэгт мөн адил) архидан согтуурах нь нийгмийн асуудал болсон бөгөөд 3 дахь өдөр болгоныг архигүй өдөр болгон зарлаж, архи согтууруулах ундаа худалдаалахыг хориглосон. Төслийн нөлөөллийн бүс дэхь сумдын эрүүл мэндийн мэргэжилтнүүд Орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, хамгаалалд нөлөөлөх байдлын үнэлгээ (ОНИАБХНБҮ) – ний судалгааны багт тайлагнаснаар: Хурцадмал архины хордлого болон архидалттай холбоотой осол гэмтлүүд тогтмол илэрч байгаа аж.³⁵ Өсөн нэмэгдэх гэмт хэрэг, нийгмийн эсрэг ёс суртахуунгүй үйлдэл нь Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо сумуудын хүрэлцээ муутай байгаа цагдаагийн хэлтсүүдэд ачаалал үүсгэх болно.

Оюу Толгой болон тус бүс нутаг дахь бусад уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд гадаадын иргэд нэмэгдэж, тээвэрлэлт нэмэгдэж, Хятад улсын хил урт хугацаагаар нээлттэй болсноор хүний наймааны гэмт хэрэг нэмэгдэж эрсдэл учирч болзошгүй. 2010 онд Оюу Толгой ХХК-д зориулсан ОНИАБХНБҮ нь одоогийн байдлаар хүний наймааны болзошгүй эрсдлүүд бага хэмжээнд байгаа бөгөөд тухайн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа ихэсч, орон нутагт хүн ам нэмэгдэхийн хэрээр шинэ асуудлууд үүсэх магадлалтай (Оюу Толгой болон бусад төслүүдтэй холбоотойгоор) гэжээ.

Төслийн орон нутгийн ажилчдын аюулгүй, эрүүл мэнд нь ажлын цагийн хуваарилалт болон ажилчид хоорондын болзошгүй зөрчилдөөний улмаас аюулд учрах боломжтой. Ялангуяа ажил хийдэг эцэг эх (ихэнхдээ эрчүүд) 3 долоо хоног эзгүй байж (3 долоо хоног ажиллаж, 1 долоо хоног амрах), бусад эцэг эх өдөр тутмын ажилтай үед хүүхэд хараа хяналтгүй үлддэг. Иймээс эцэг эхийн ажлын үүрэг хариуцлагаас үүдэн сургуулийн болон сургуулиас өмнөх насны хүүхдүүд хараа хяналтаас ангид байх буюу хяналт хангалтгүй байдаг байна. Одоогийн байдлаар хүүхэд асрах тохиромжтой үйлчилгээний байгууламжууд байхгүй бөгөөд цэцэрлэгүүд ачааллаа дийлэхгүй байна. Иймээс гэр бүлийн хүмүүсийн тусдаа байх явдал, ядуурал, архидалт зэрэг нь стресс үүсгэж гэр бүл салалтанд хүргэж байгаа тухай мэдээ байна.³⁶

2010 онд барилгын ажлын үеийн ажиллах хүчтэй холбоотой осол гэмтлүүд нилээд гарсан. Эдгээрт өөр өөр улсын ажилчид хоорондын зөрчилдөөн, дотоодын ажилчдын зөрчилдөөн, орон нутгийн Монгол эмэгтэй ажилчдын ажлын байранд дарамт учруулсан талаарх бүртгэгдсэн мэдээллүүд орно. Рио Тинто-гийн Олон Нийт ба орон нутгийн иргэдийн аюулгүй байдлын хэлтэс нь 2010 оны 11 сард Оюу Толгой төсөл дээр Ажиллах хүчний зөрчилдөөний үнэлгээ хийсэн бөгөөд үүнд төсөл болон орон нутгийн хэмжээнд илэрч болзошгүй нөлөөллийг тусгасан³⁷. Үнэлгээний баг нь дотоод болон гадаадын өргөн хүрээний оролцогч талуудтай уулзаж, гарч болзошгүй эрсдэл болон зөрчлийг тодорхойлсон. Эдгээр зөрчлүүд гарч хүчирхийлэл болохоос урьдчилан сэргийлэхийн тулд үнэлгээний баг хэд хэдэн зөвлөмжүүдийг гаргав. Эдгээр ажилчидтай холбоотой асуудал нь Оюу Толгойн анхаарал хандуулахуйц асуудал мөн. Ажилчдын хоорондын зөрчилдөөний үнэлгээний дагуу Оюу Толгой ХХК нь өөрийн Уурхайн талбайд аюулгүй байдалд авах арга хэмжээ: Ажиллах хүчний хүчирхийлэл сэдэвт төлөвлөгөөг 2011 оны 1-р сард боловсруулсан.³⁸ Энэхүү төлөвлөгөөний зорилтууд нь Оюу Толгойн ажилчид, өмч хөрөнгө, нэр хүндийг хамгаалахад чиглэгдэнэ.

2011 онд хийгдсэн удаа дараагийн уулзалтуудад ард иргэдэд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, санал гомдол хүлээн авч, Оюу Толгойн ажилтан, албан хаагчид болон Ханбогд сумын засаг даргатай уулзах үедээ CIS-тэй холбоотой асуудлыг тодруулж, санал гомдлын талаар сүүлийн үеийн мэдээлэл хүргүүлсэн бөгөөд орон нутгийн иргэдийн төлөөлөл болон CIS-ийн менежментийн удирдлага мөн улзалт зохион байгуулсан.

Нөлөөлөл бууруулах арга хэмжээ

³⁴ ДЭМБ, Орон нутгийн хамтын ажиллагааны стратеги, Монгол улс 2006 он, Бүлэг В15: Орон нутгийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалалт (суурь нөхцөл) – дурдсан ишлэлийн дагуу.

³⁵ Оюу Толгой төслийн Орон нутгийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалалтад нөлөөлөх байдлын үнэлгээ, ХТХК, 2011 он (ХТХК-ын 2010 онд явуулсан хээрийн судалгаа).

³⁶ *Ibid*, ОНИАБХ-ын нөлөөллийн үнэлгээ, ХТХК 2011.

³⁷ Оюу Толгойн Зөрчилдөөний Үнэлгээ. Рио Тинто ба Оюу Толгойн дотоод бичиг баримт. 2010 оны 10-р сар.

³⁸ Оюу Толгойн аюулгүй байдалд хариу авах арга хэмжээний төлөвлөгөө, 2011 оны 1-р сар.

Төслийн нөлөөллийн бүсрүү шилжин хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас үүсэх нөлөөллийг бууруулахын тулд Оюу Толгойн авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах хэсэгт авч үзэв.

Бэлчээрт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг Бүлэг С10: Газар ашиглалт болон шилжилт хөдөлгөөн хэсэгт дэлгэрэнгүй тусгав. Үүнтэй нэгэн адил хувь хүний аюулгүй, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар Бүлэг С12: Орон нутгийн эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хамгаалал хэсэгт авч үзэв.

Хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулах ерөнхий хандлага

Хүн амын шилжилт хөдөлгөөний менежменттэй холбоотой Оюу Толгойн бодлого болон хөтөлбөрүүд нь 2007 оны Хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгэний зөвлөмжүүдэд суурилсан. Оюу Толгойн Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийг боловсруулахад ашигласан нэмэлт мэдээлэлд төслийн шинэчлэгдсэн шийдэл, шинэчлэгдсэн орон сууцны загварчлал (Ханбогд төвтэй), орон нутгийн захиргаа болон иргэдтэй тогтмол хийгддэг хэлэлцүүлгийн үр дүн, Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан шаардлагууд зэрэг орно.

Оюу Толгой ХХК нь хүн амын шилжилт хөдөлгөөн, шилжин ирэх чиглэлд шууд хяналт тавих боломжгүй боловч уг төсөл нь өөрийн хяналт төлөвлөгөөтэйгээр ажилд элсүүлэх, зуучлах, ажиллах хүчний орон сууцны зохицуулалт хийх замаар өөрийн ажилчид болон нийлүүлэгчдийн хөдөлгөөнд нөлөө үзүүлж чадна. Ялангуяа уг төсөл нь дараах асуудлуудад хяналт тавьж чадна:

- Хаана ажилчдыг элсүүлэхийг: ингэснээр ажилд элсүүлэх зориулалтын газруудаас бусад хуурамч/эрхгүй, албан бус ажил олгогчид гарч ирэхээс урьдчилан сэргийлэх,
- Ажилчдын орон сууц хаана байрлахыг: ингэснээр уг асуудлаар албан бус, хяналтгүй суурин үүсэхээс урьдчилан сэргийлэх,
- Эрчим хүч, усан хангамж, ариун цэвэр болон ажиллах хүч ба орон нутгийн иргэдэд олгох бусад хангамжийн үйлчилгээний чанар ба хүртээмж мөн эдгээр үйлчилгээнүүдийн чанар доголдсон дэд бүтцийн элементүүдэд, ,
- Ажилчид хаана болон яаж ажилд орж, халагдахыг тооцон үзсэнээр төсөлд орон нутгийн ажиллах хүч элсэх боломжийг нэмэгдүүлж, ажиллах хүчний хөдөлгөөн болон урсгалыг тохируулна,
- Ажилчдын төслийн нөлөөллийн бүс дэхь ард иргэдтэй харилцах түвшин, зан байдлыг хянах, үүнийг ажилчдад зориулалтын суурин бариулж, төслийн болон гэрээт гүйцэтгэгчдийн ёс зүйн хэм хэмжээг тогтоож хэрэгжүүлсноор зохицуулна,
- Орон нутгийн ажиллах хүчинд зориулж сургалт, дадлагажуулах тал дээр хөрөнгө оруулалт хийснээр төслийн нөлөөллийн бүсээс гаднах нутгаас хүний нөөц авах хэрэгцээг бууруулна,
- Орон нутгийн болон бүс нутгийн үйлчилгээ нийлүүлэгчдийг эрхэмлэж, ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг дэмжснээр орон нутгийн бизнес хөгжих үндсийг тавьж, чадавхижуулна.

Дараах хэсэгт хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас үүссэн сөрөг нөлөөлөл бууруулах чиглэлээр төслийн авах арга хэмжээнүүд, хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас орон нутгийн ард иргэдэд учруулах сөрөг нөлөөлөлд бага өртөх явдлыг хангах чиглэлээр Оюу Толгой ХХК-ны авах үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус тусгав.

Орон нутгаас ажиллах хүч элсүүлэхийг дэмжих

Төсөл нь ажилд элсүүлэх дүрэм журмыг боловсруулсан бөгөөд эдгээр нь дараах зорилготой:

- Ажил горилох өндөр хүлээлттэй эдийн засгийн боломж эрэлхийлсэн шилжин ирэгсдийн төслийн нөлөөллийн бүст шилжин ирэх хөдөлгөөнийг зогсоох,
- Уурхайн аюулгүй, хамгаалалттай байдлыг хэвээр хадгалах,
- Төслийн ажлын талбар дотор болон гадна иргэд шилжин очих магадлалыг багасгах

Оюу Толгой нь өөрийн ажилтан элсүүлэх стратегийн хүрээнд төслийн нөлөөллийн бүсийн сумдууд (Ханбогд, Манлай, Баян-овоо, Далагзадгад) болон Өмнөговь аймгийн бусад газар нутгаас ажилтан

элсүүлэхийг эрхэмлэнэ. Энэ нь Хөрөнгө оруулалтын гэрээнд тавигдсан шаардлагуудтай нийцэж байгаа юм. Тухайлбал:

- Заалт 4.8 “Хөрөнгө оруулагч нь Өмнөговь аймгийн ард иргэд болон Оюу Толгой төслийн нөлөөлөлд шууд болон шууд бусаар өртөх бүлэглэлд гол анхаарлаа хандуулна”
- Заалт 4.11 “Хөрөнгө оруулагч нь өмнө Говийн бүсийн, ялангуяа Өмнөговь аймгийн орон нутгийн иргэдэд зориулж мэргэжлийн сургалт зохион байгуулж, ажилд олгох боломжоор тус тус хангах явдалд түлхүү анхаарна”
- Заалт 8.5.1 “Төслийн барилгын ажил болон өргөтгөлийн ажлын үеэр ажилд авсан нийт ажилчдын 60%-иас доошгүй нь Монгол улсын иргэн байна”
- Заалт 8.5.2 “Уурхай болон уурхайтай холбоотой ажлын хувьд нийт ажиллах хүчний 75%-иас доошгүй нь Монгол улсын иргэн байна”

Орон нутаг / бүсээс ажиллах хүч авч, орон нутгийн нөөцийн ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулахыг эрхэмлэх нь төслийн газар нутгаас бусад газраас шилжин ирэх ажилчдын хэрэгцээг багасгах ач холбогдолтой. Энэхүү арга зам нь дараах арга хэмжээгээр хэрэгжинэ. Үүнд:

- Зөвхөн зориулалтын газруудаас орон нутгийн ажилтан элсүүлэх бөгөөд “уурхай дээр шууд очиж ажилд орох” явдал үгүй байх хатуу бодлого баримтална. Төслийн талбайруу шилжин ирэх албан бус хүн амын шилжилт хөдөлгөөнийг багасгахын тулд Оюу Толгой нь барилгын ажлын үед түр зуурын ажлын байр болон барилгын ажил явагдаж буй суурингуудад ажилд авахгүй байх мөн төслийн хэрэгжилтийн үед уурхайн хаалга / байран дээр ажилтан элсүүлэхгүй байх зарчим баримтална.
- Ханбогд суманд хяналтгүй, эрсдэлтэй ажил олгох явагдахаас урьдчилан сэргийлж, амар хялбар ажилд орох боломж горилсон шилжин ирэгсдийн урсгалыг зогсоохын тулд албан бусаар ажилд элсүүлэлтийг хориглоно.

Оюу Толгойн авч хэрэгжүүлж буй ажилтан элсүүлэх дүрэм журмыг олон нийтэд нээлттэйгээр сайн сурталчилж байгаа бөгөөд ажлын байрны талаарх шаардлага болон тайлбарын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгч байгаа бөгөөд энэ нь шаардлага хангахгүй ажил горилгогч нарын урсгалаас урьдчилан сэргийлж, ажил горилгогч нар албан бус арга замаар ажил горилох боломж гаргахаас урьдчилан сэргийлнэ.

Оюу Толгойн орон нутгийн иргэдийн ажлаар нэн тэргүүнд хангах бодлого болон холбогдох арга хэмжээний талаар бүлэг С 9: Ажил эрхлэлт болон бүлэг D 17: Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө хэсэгт тус тус тусгав.

Ажилчдын орон сууц

Оюу Толгой нь өөрийн ажилчдыг орон сууцаар хангах явдалд дараах арга хэмжээг хослуулна:

- Барилгын ажиллах хүчинд зориулсан суурин хэлбэрийн амьдрах байгууламжууд
- Уурхайн үйлдвэрлэлийн үе шатанд Ханбогд-төвтэй орон сууцны “ **орон нутгийн цогц загвар**”-ын арга.

Барилгын ажлын кэмпүүд

Оюу Толгой ажиллах хүч нь барилгын ажлын оргил үед 12 900 гаруйд хүрнэ. 2010 оны 5-р сарын байдлаар төслийн ажиллах хүчний 16%-ийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж байв. 2010 оны сүүлчээр Оюу Толгой болон түүний гэрээлэгчидэд ажил эрхэлж буй Ханбогд³⁹ сумын иргэд 629 хүрсэн. 2011 оны 2-р сарын байдлаар төслийн нийт 5513 ажилчдаас (гэрээлэгчдийг оролцуулаад) 3789 ажилчид нь Монгол улсын иргэд байв. Эдгээр ажилчид нь барилга, кемпийн удирдлага зохион байгуулалт, хоолны, өрөмдлөг, газрын шорооны ажил, угсралт тоноглол, засварын ажил зэрэг өөр өөр хариуцлагын ажилд ажиллаж байна.

Төлийн барилгын үе шатанд эдгээр ажилчид нь уурхай дээрх зориулалтын тосгон орон сууц, эсвэл Ханбогд суман дахь зориулалтын тосгонуудад аж төрж автобусаар-ирэх-буцах (АИАБ) замаар

³⁹ Эдгээр үзүүлэлт нь Ханбогд сумын уугуул иргэдийг илтгэсэн бөгөөд Монгол орны бусад нутгаас Ханбогд суманд ирж суурьшсан хүмүүсийг тооцоогүй.

зорчих болно. Ханбогд сумын орон нутгийн ажилтангууд уурхайруу өдөр тутам явах тээврийн хэрэгслээр зорчиж, бүх ажилчидын нэгэн адил ээлжийн ажлын зарчмаар ажиллана.

Ханбогд сумаас бусад газраас ажилд орсон бүх барилгын ажилчид нь дараах зориулалтын барилгын кемпүүдэд байрлана. Үүнд:⁴⁰

- Оюу Толгойн барилгын кемп (2,451 ортой);
- Хятад улсын гэрээт ажилтнуудад зориулсан гэрээт гүйцэтгэгчдийн нэгдсэн кемп (4,704 ортой);
- Ханбогдын барилгын кэмп (CIS компани) (1,536 ортой);
- Барилгын түр кэмп – Хойд болон өмнөд, ус дамжуулах шугам хоолой болон Хятад улсруу чиглэх зам дагуу байрлах бөгөөд кемп тус бүр нь ойролцоогоор 1,000-1,500 хүний хүчин чадалтай,
- Ханбогд дахь барилгын ажилчдын түр кэмп - 750 ортой.

Барилгын ажлын үеэр ажилчид (Оюу Толгойн ажилчид болон барилгын гэрээлэгчид) төслийн талбай дээрхи кемпүүдэд амьдрах бөгөөд амралтын үеэр кемпийг орхин явах эрхгүй. Бүх барилгын гэрээт гүйцэтгэгчдийн кемпүүд нь бие даасан, хэрэгцээгээ дотроосоо хангадаг зарчмаар ажиллах ба ингэснээр уурхайн ажилчид хөрш зэргэлдээх орон нутгийн хүн амтай харилцаанд орох боломжийг хязгаарлаж, орон нутгийн дэд бүтцийг ашиглах ачааллыг багасгана⁴¹. Уурхай дээр гэр бүлээр суух сууц байхгүй боловч орон сууцны тодорхой шалгуур хангасан, албан ёсны ажилчидад зориулсан ийм хэлбэрийн сууц Ханбогд суманд бий.

Уурхайн үйлдвэрлэлийн үе шатны ажилчдын орон сууц

Оюу Толгойн санал болгосон Ханбогд-төвтэй орон сууцны загвар нь Ханбогд сумыг эдийн засгийн төв төдийгүй өндөр чанартай орон сууцтай, худалдан авах боломжтой төв болгон сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Оюу Толгой төслийн тусламжтайгаар боловсруулсан Ханбогд сумын шинэчилсэн бүсчлэл, газар ашиглах төлөвлөгөөг сумын хурлаар баталсан ба Ханбогд сумыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг Ханбогд сумын хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар АХБ-ны дэмжлэгтэйгээр 2011-2012 онд боловсруулах болно.

Ажлын ээлж болон тээврийн шаардлагын тухай өнөөгийн төлөвлөгөөг доорхи байдлаар тоймлов:

- Ханбогд сумаас ажилд элссэн, өдрийн болон шөний ээлжээр ажилладаг бүх Монгол ажилчид Ханбогд сумын төврүү/төвөөс автобусаар (автобусаар ирэх буцах) зорчино,
- Орон нутгын биш ажилчид 8-2 долоо хоногийн ээлжээр ажиллаж, 8 долоо хоногийн ажлын үеэр уурхай дахь кемпэд байрлана. Эдгээр ажилчид амралтын 2 долоо хоногийн хугацаандаа өөрийн гэр байрладаг сум/бусад байршлууд руу зорчих зайнаас хамааран “АИАБ” эсвэл онгоцоор-ирэх-онгоцоор-буцах буюу “ОИОБ” зарчмаар зорчино.
- Гадаадын ажилчид нь уурхай дээр байрлаж, 6 долоо хоног ажиллаж 2 долоо хоног амрах ээлжтэйгээр ээлж тус бүрт 12 цагаар ажиллаж (эсвэл бусад ээлж), өөрийн эх оронруугаа “ОИОБ” замаар ирж/буцна.
- Оюу Толгой ХХК-ны удирдлагууд нь Оюу Толгойн уурхай болон Улаанбаатарын хооронд 5 өдөр ажиллаж 2 өдөр амрах ээлжээр ажиллана.

Цахилгаан, Эрчим Хүчний Хангамж

Оюу Толгой төсөл нь орон нутгийн эрчим хүчний хэрэглээнд туслалцаа үзүүлэхийн тулд Ханбогд сумын төвийн цахилгаан үүсгүүрийг сүүлийн хэдэн жилд дизел түлшээр хангаж ирсэн. Төсөл нь

⁴⁰ Үйл ажиллагааны Хөгжлийн Цогц Төлөвлөгөөний Хэсэг 13.8-аас иш татав

⁴¹ Оюу Толгойн Кемп дээр бие авч явах болон зайн байдлын дүрэмийг үзнэ үү.

өөрийн цахилгаан хангамжийн асуудлаа уурхай дээрх дизел хөдөлгүүрт үүсгүүрүүдээ ашиглан биеэ даан шийдвэрлэдэг.⁴²

Төсөлтэй холбоотой үүсч буй хүн амын шилжих хөдөлгөөний урсгалын улмаас өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт хэрэгцээг хангах нэмэлт цахилгаан үүсгүүрүүд шаардлагатай байгааг мөн орон нутгийн эрчим хүчний үүсгүүр болон түгээх системд засвар шинэчлэл хийх шаардлагатай байгааг Оюу Толгой төсөл ойлгож байгаа .

Эрчим хүч болон дулаан хангамжийг өөрийн нөлөөллийн бүсдээ сайжруулах тал дээр Оюу Толгойн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дараах арга хэмжээ хамаарна. Үүнд:

- Ханбогд сумын одоогийн цахилгаан түгээх сүлжээг сайжруулах зорилгоор 35 Кв хүчин чадалтай цахилгаан шилжүүлэх шугамын барилгын ажилд санхүүжилт үзүүлэх
- АХБ-ын санхүүжилттэй Ханбогд суманд хэрэгжиж буй хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор дүүргийн дулааны системийг шинэчлэх

Дүүргийн дулаан хангамж сайжруулах ажилд одоо ажиллаж буй системийг өргөтгөж, засаж сайжруулж, мөн шаардлагатай тохиолдолд дахин шинэ системээр хангах ажлууд орно. Төсөл нь илүү сайн халаалтын системээр хангахын тулд шинэ бойлер, шахуурга, бойлерын байшингаар хангаж зарим тохиолдолд одоо ажиллаж буй хангалтгүй шугам хоолойг солино.

Усан Хангамж Болон Хяналт Шинжилгээ

Усны Хяналт Шинжилгээ

Төслийн барилгын ажлын үр дүнд орон нутгийн малчдын худагт их хэмжээний шууд нөлөөлөл үзүүлэхгүй хэмээн таамаглал гарсан боловч төслийн усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нэг хэсэг болгон сонгон авсан малчдын зарим худагт хяналт шинжилгээ хийнэ. Оюу Толгой нь одоогийн байдлаары 333 малчдын худагт хяналт шинжилгээ хийдэг байна. Оюу Толгой ХХК нь усны түвшин болон чанарт хяналт шинжилгээ хийх энэхүү үйл ажиллагаа малчид иргэдэд нээлттэй ил тод явагдаж, төсөл болон орон нутгийн иргэдийн хоорондын итгэлцлийг сайжруулах зорилгоор орон нутгийн иргэдтэй хамтарсан Хамтын оролцоот хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно. Хэрэв хяналт шинжилгээний явцад аливаа асуудал илэрсэн тохиолдолд, Оюу Толгой нь нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтран ажиллаж, тухайн асуудлын талаар хоёр талд зөвшөөрөхүйц шийдэлд хүрэхийн төлөө ажиллана (шинэ худаг өрөмдөх замаар усан хангамжийн өөр эх үүсвэрийг илрүүлэх).

Ханбогд сумын усан хангамжийг зохицуулах

Ханбогд сумын захиргаа нь Оюу Толгой төслөөс өөрийн сумын ойр хавьд **гүний усны хайгуул** хийж өгөхийг хүссэн хүсэлт тавьсан бөгөөд энэ нь дараах зорилготой:

- Ханбогд сумын өсөн нэмэгдэж буй хүн амын усан хангамжийг шийдэхийн тулд хангалттай, тогтвортой усан хангамжийн эх үүсвэрийг олж тогтоох
- Өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг хангахын тулд газрын доорхи усны боломжит нөөцийг тогтоох

Энэхүү шаардлага нь Монгол улсын Засгийн газрын хот төлөвлөлт, хөгжилтэй холбоотой асуудлаар хөрөнгө оруулагч дэмжлэг үзүүлэх тухай Хөрөнгө оруулалтын гэрээний заалттай нийцэж байгаа бөгөөд энэ хүрээнд усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх асуудал орно. Оюу Толгой нь цооног өрөмдөх хөтөлбөрийн хүрээнд олон , нарийвчилсан судалгааг амжилттай явуулж, их гарцтай, давслаг биш, ундны усанд тохиромжтой гүний усны нөөцыг шинжилж тогтоосон. Өрөмдлөг явуулсан цооногийн нийт тоо хэмжээний хувьд 7 цооногийг 1312 м өрөмдсөн, 7 хайгуулын цооногийг 1294 м мөн ус татах 3 цооногийг 370 м өрөмдсөн.

Гүний усны химийн найрлагыг шалгасан бөгөөд усны чанар нь Монгол улс болон ДЭМБ-ын усны чанарын стандартын шаардлагыг хангаж байна. Үүний дүнд аливаа бактерилогийн бохирдол илрээгүй. Усны хэрэглээ болон үйл ажиллагааны үед аливаа эрсдэл учирахаас урьдчилан

⁴² Ханбогд суманд байрлах Оюу Толгойн кэмп өөрийн дизель цахилгаан үүсгүүртэй бөгөөд цахилгаан хэрэгцээгээ бүрэн хангадаг.

сэргийлэхийн тулд газрын гадарги дээрх хадгалах байгууламжаас гарах эцсийн шат дамжлагад хлоржуулалт хийх эсвэл үүнтэй ижил төрлийн арга хэмжээ (хэт ягаан туяагаар ариутгах) авна.

Тогтоогдсон усны нөөцийн хэмжээг тодорхойлох мөн ус хадгалах байгууламжаас ус хангах явдалд зориулсан нарийвчилсан загвар төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд төсөл одоогийн байдлаар илүү дэлгэрэнгүй үнэлгээг явуулж байна. Усан хангамжийн систем барих ажлын капитал зардлыг Ханбогд сумын удирдлагад Оюу Толгой ХХК-с төлөх усны төлбөрийн оронд нөхөн төлөөс маягаар гаргана. Энэхүү санаачлагыг хэрэгжүүлэхэд АХБ нь хамтрагч болон ажиллаж, ус түгээх систем байгуулахад санхүүжилт өгч, холбогдох байгууллагуудад шинэчлэлт хийхэд туслалцаа үзүүлж ажиллах төлөвлөгөөтэй байна.

Ариун цэврийн нөхцлийг сайжруулах

Оюу Толгой төсөл нь уурхай дээрээ бие даасан бохир усыг үр ашигтай дахин боловсруулж цэвэрлэх байгууламж ажиллуулдаг. Одоогийн байдлаар цэвэрлэсэн бохир усыг тоосжилт дарах зорилгоор ашиглаж байна. Төслийн шинэ ус ашиглах хэрэгцээг багасгах зорилгоор төслийн барилгын үе шатанд цэвэрлэсэн бохир усыг барилгын цемент боловсруулах үйл ажиллагааны усны хэрэгцээнд ашиглаж байна.

Монгол улсын Засгийн газар болон АХБ нь одоогоор Ханбогд суманд бохир усны системийн сүлжээ болон цөөрмийн цэвэрлэх байгууламж байгуулах чиглэлээр туслалцаа үзүүлж байна. Энэхүү алхмыг дэмжихийн тулд уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэх үед Оюу Толгой нь өөрийн түр зуурын барилгын тосгонуудад хэрэглэгдэж байгаа эрэмблэн-ялгах-реакторын бохир ус цэвэрлэх байгууламжуудаа Ханбогд сум руу шилжүүлнэ. Ханбогд сумын захад орших CIS-н кемпүүд нь одоогоор бохир ус цэвэрлэхийн тулд ууршуулах цөөрөм ашиглаж байна. Тунасан хатуу бохирыг зайлуулж, УЛТД ажиллаж буй хаягдлын цөөрөмд шилжүүлж, ууршуулах цөөрөмийг биологийн аргаар бохир ус цэвэршүүлэх байгууламжаар солих болно.

Хатуу хог хаягдал

Хатуу хог хаягдлын хувьд, Оюу Толгой төсөл нь өөрийн үйл ажиллагааны улмаас үүсэх бүх хаягдлыг цуглуулж, хаягдал дахин боловсруулах дарж булж устгах эрх олгогдсон зориулалтын цэгүүдрүү зөөвөрлөнө.⁴³ Энэхүү ажилд шинэ хог дарж булж устгах цэгүүд, хаягдал цуглуулах, булах төхөөрөмжүүдээр хангах ажил багтана.

Оюу Толгой төсөл нь хог хаягдлын менежментээ биеэ даан хэрэгжүүлнэ. Одоогийн байдлаар Оюу Толгой төсөл зөвхөн өөрийн үйл ажиллагаанаас ялгарсан хаягдлыг менежментийн цэг ажиллаж байна. Энэхүү дунд хугацааны хаягдал цэвэрлэх байгууламж нь түр зуурын хугацаатай ба зориулалтын **Хог Хаягдлын Менежментийн Төвийг** төслийн үйлдвэрлэлийн шатанд зориулж УЛТ-н зүүн хойд хэсэгт байгуулна. Хаягдлын менежментийн төв нь тусгаарлагч давхрага бүхий дарж булж устгах үүрээс бүрдэх бөгөөд ялгарсан хаягдал шингэний уургуулах 2 цөөрөмийг уурхайн арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгуулах болно. Төслийн үйл ажиллагаа дараагийн шатанд шилжин өрнөхийн хэрээр дарж булж устгах цэг болон хаягдал ууршуулах цөөрмийг дахин боловсруулах буюу бордоо бэлтгэх байгууламжуудын хамтраар барина. Дахин боловсруулж болох метал, модыг орон нутгийн гэрээт байгууллагууд цуглуулж дахин боловсруулах болно.

Оюу Толгой, Монгол улсын Засгийн газар, болон АХБ нь хамтран Ханбогд суманд хаягдал цуглуулах систем, зориулалтын хог дарж булах цэгүүд байгуулах ажлыг хамтран дэмжин ажиллаж байна.

Эмнэлгийн үйлчилгээ

Оюу Толгой нь өнгөрсөн хэдэн жилд орон нутгийн иргэдэд зориулсан эмнэлгийн үйлчилгээний чанар болон хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэд хэдэн санаачлагуудыг хэрэгжүүлсэн билээ. Үүнд:

- 23 эмчид 5 жилийн тэтгэлэг үзүүлэх хөтөлбөр (2004-2009). Одоогийн байдлаар, мэргэшиж дадлагажсан 14 эмч Өмнөговь аймагт ажиллаж байна;

⁴³ Дэлгэрэнгүйг Бүлэг D8: Хог хаягдлын менежмент төлөвлөгөө-с үзнэ үү.

- 2006 – 2008 оны хооронд Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвүүдийг 12 суманд байгуулсан ба энэхүү хөтөлбөрийг санхүүжүүлэхэд нийт 300,000 ам доллар зарцуулсан. ;
- Ханбогд суманд шүдний эмнэлэг байгуулсан;
- Өмнөговь аймагт эрүүл мэндийн байгууллага болон үйлчилгээний хүртээмжийн талаар судалгаа явуулсан (бүлэг В13: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал-г үзнэ үү). Оюу Толгой нь эмчийн тэтгэлгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байх бөгөөд Жавхланта багт гэмтэл согогийн төвийг мөн байгуулна.⁴⁴

Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээг хангах нь Монгол улсын Засгийн газар, холбогдох аймаг, сумын удирдлагын үндсэн үүрэг хариуцлага хэвээр байна. Энэхүү үйл ажиллагааг дэмжиж, Засгийн газрыг эрүүл мэндийн үйлчилгээ хангах төлөвлөгөөг боловсруулахад туслалцаа үзүүлэх зорилгоор Оюу Толгой төсөл нь өөрийн урт хугацааны Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал хангах хөтөлбөрийн (ОНИЭМАБХХ) нэг хэсэг болгон Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ЭМНБҮ) хийв. ЭМНБҮ-г Хөх тэнгэр хөгжил консорциум (ХТХК) 2010 оны 6-р сард эхлүүлж хэрэгжүүлсэн. Энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн урт хугацааны хөтөлбөрийг дараах байдлаар боловсруулагдана⁴⁵. Үүнд:

- 1-3 жилд, ажлыг дэлгэрэнгүй тайлбарлаж, санхүүг нь гаргаж, орон нутгийн иргэдэд зориулсан нэн тэргүүнд шаардлагатай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх мөн түүнчлэн урт хугацааны өргөн хүрээтэй ОНИЭМАБХХ-ыг боловсруулахын тулд олон талт оролцогчдод ытулгуурласан байх,
- 3-6 жилд, Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудлыг сайжруулах хөтөлбөрүүдийн чанар хүрээг нэмэгдүүлэх . Үүнд холбогдох нэмэлт оролцогч талуудын идэвхитэй оролцоо шаардагдана.
- 20 жилд, Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалтай холбоотой ирээдүйн өргөн хүрээний зураглал тодорхой болж, энэхүү зураглал, зорилтод хүрэх боломжит арга замыг тодорхойлно.

ОНИЭМАБХХ нь эрүүл мэндийн системийн аргачлалыг ашиглаж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) тодорхойлсон эрүүл мэндийн системийг сайжруулах 6 үндсэн асуудалд анхаарал хандуулна. Үүнд:

- *Үйлчилгээний хүртээмж;*
- *Эрүүл ажиллах хүч;*
- *Мэдээлэл түгээлт;*
- *Эмнэлгийн бүтээгдэхүүн, вакцин, технологи;*
- *Санхүүжилт;*
- *Манлайлал/засаглал*⁴⁶.

Эрүүл мэндийн үйлчилгээг нийлүүлж, удирдлагаар хангахад улсын сектор үндсэн үүрэг гүйцэтгэдэг учир, ОНИЭМАБХХ нь Монгол улсын Засгийн газрын батлан гаргасан одоо хэрэгжиж буй эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын санаачлагууд болон тодорхой хэмжээнд төрийн бус байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Мянганы сорилын сан, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр зэрэг донор байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдэд нэмэлт тусламж үзүүлэх хүрээнд боловсруулагдах болно.

Хувийн сектор бүрэн давамгайлсан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх хувилбарын зарим дутагдлыг анхааран үзсний үндсэн дээр ОНИЭМАБХХ-ын стратеги зорилт нь уг хөтөлбөрийг аажимдаа ирээдүйд эзэмшигч нарыг бий болгохын тулд улсын секторын тоглогч нарыг (шаардлагатай

⁴⁴ Оюу Толгой төслийн Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх тэнгэр хөгжил консорциум (ХТХК), 2011 (ХТХК-ын 2010 онд гүйцэтгэсэн хээрийн судалгаа).

⁴⁵ Оюу Толгой төслийн Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй байдал, хамгаалалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх тэнгэр хөгжил консорциум (ХТХК), 2011 (ХТХК-ын 2010 онд гүйцэтгэсэн хээрийн судалгаа).

⁴⁶ http://www.searo.who.int/LinkFiles/Health_Systems_EverybodyBusinessHSS.pdf үзнэ үү

тохиолдолд иргэний нийгэм) дэмжих, байгууллагын болон хувь хүний чадавхийг сайжруулах механизмыг нэгтгэхэд оршино. Үүний тулд, хөтөлбөр нь тогтвортой байдал дээр онцгой анхаарал хандуулж, холбогдох улсын секторын агентлаг, байгууллага тухайлбал Эрүүл мэндийн яам, аймгийн эрүүл мэндийн салбар, сумын эмнэлэг, Улсын мэргэжлийн хяналтын газартай ойр хамтран ажиллана.

Бүлэг В13: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хэсэгт орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал болон хамгаалалт, холбогдох менежментийн төлөвлөгөө болон нөлөөлөл бууруулах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулав.

Боловсролын шаардлага

Хөрөнгө оруулалтын гэрээний Заалт 8.12-н дагуу Оюу Толгой нь өөрийн хэрэгцээ шаардлага болон орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд хэрэгцээтэй ур чадварт сургах сургалтын стратегийг Монгол ажиллах хүчинд зориулан боловсруулсан. Оюу Толгой ХХК нь урт хугацааны мэргэжлийн сургалт, тэтгэлэлт хөтөлбөр, дадлага ажил хийх хөтөлбөрүүдийг боловсруулж орон нутгийн ажилчдын уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдлэг туршлагыг сайжруулах зорилт тавьж байна. Сургалт нь барилгын, механик, ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдал, сувилал, үйлдвэрийн үйл ажиллагаа, нарийн бичгийн ур чадвар, техникийн/инженерийн мэргэжил дээр голлон төвлөрнө. (Оюу Толгойн сургалтын шаардлага болон үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг С9: Ажил эрхлэлт болон Бүлэг D17: Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө хэсгээс үзнэ үү)

Түүнчлэн, төсөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Ханбогд сумын сургуулиудын өргөтгөлийг хийх ажлыг Монгол улсын Засгийн газартай хамтран санхүүжүүлэх
- Ханбогд сумын цэцэрлэгийн өргөтгөлийг барих
- Одоо байгаа 5 техникийн болон мэргэжлийн сургалтын коллежыг тохижуулж Даланзадгад болон Налайх хотуудад 2 шинэ мэргэжлийн сургалтын коллеж байгуулах Мөн,
- Ханбогд суманд шинэ цэцэрлэг барих явдалдэмжлэг үзүүлэх тухай Оюу Толгой харгалзан үзэж байгаа бөгөөд Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг хувийн сургалтын байгууллагууд Ханбогд суманд өөрийн байгууламжаа байгуулах талаар хэлэлцэгдэж байгаа.

Нөлөөллийн ач холбогдол

Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс нутагруу шилжин ирэх хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбоотой үүсэх нөлөөлөл нь **орон нутгийн шинжтэй, дунд зэрэг сөрөг** үзүүлэлтэй бөгөөд тохиолдох магадлал нь **тодорхой** ба барилгын ажил болон уурхайн үйл ажиллагааны үеэр уг нөлөөлөл нь хуримтлагдан, **дунд хугацаагаар үргэлжлэх** төлөвтэй гэж үзэв. Дээр дурьдсан сөрөг нөлөөлөл бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ нь эдгээр нийт нөлөөллүүдийн үлдэгдэл нөлөөллийн ач холбогдлыг **бага хэмжээнд** хүртэл бууруулах боломжийг олгоно. Өнөөдрийг хүртэл цуглуулсан баримтаас үзэхэд шилжин ирэх хөдөлгөөн харьцангуй байга байсан учраас нөлөөллүүд бага хэмжээнд байв. Ирээдүйд шилжин ирэх хөдөлгөөний хэмжээг таамаглах хэцүү болохыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийснээр үйлдвэрлэлийн шатны талаархи шинэчлэгдсэн мэдээлэл болон өөр бусад тодорхой болсон мэдээллүүдэд үндэслэн дээрхи үнэлгээг шинэчлэн сайжруулах боломжтой болно. Энэхүү нөлөөллийн үнэлгээг Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нэмэлт тодотголд илүү нарийн тодорхойлох бөгөөд төслийн барилга байгууламжуудын байршил болон шинж чанарын тухай илүү нарийн мэдээлэл нь нөлөөллийг илүү нарийвчлан тодорхойлж үйлдвэрлэлийн шатанд хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээнүүдийг тодорхойлох боломж олгоно.

8.3.4 Бичил Уурхайн Хяналтгүй Олборлолт

Нөлөөллийн тодорхойлолт

Ханбогд суманд хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээг 2007 онд хийх үед судалгаанд оролцсон өрхүүдийн мэдээнээс үзэхэд Ханбогд сумын зарим өрхүүд бичил уурхайнаас өрхийн

амжиргаа нь хараат бай байдаг тухай дурьдсан байна.^{47,48} Өмнө нь орон нутгийн гар аргаар алт олборлогчид нь гол төлөв Ирак толгойд төвлөрөн ажилладаг байсан (Ханбогд сумын төвөөс баруун урагш 130 км орчим зайд Говийн Бага Дархан Цаазат Газар) ба энэ нь Дорноговь аймагтай хил залгаа оршдог бөгөөд энэхүү газар нутагт хүрэхдээ Ханбогд сумаар дамжин өнгөрөх замаар хүрдэг байна.

Энэхүү судалгааг хийснээс хойш 2007 оны 5-р сард Монгол улсын Засгийн газар хууль бус гар аргаар уурхай эрхлэх үйл ажиллагааг таслан зогсоосноос хойш дахин ийм үйл ажиллагаа илрээгүй боловч хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас энэхүү ажиллагаа дахин тохиолдох магадлал бий.

Оюу Толгой төсөлтэй холбоотой бичил уул уурхайн үйл ажиллагаатай хамаатай гол асуудлуудад дараах асуудлууд орно. Үүнд:

- *Төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас шилжин ирэгсэд Оюу Толгой төсөлд албан ёсоор ажил горлох хүртлээ эдийн засгийн боломж эрэлхийлэн түр зуур тухайн орон нутагт гар аргаар уул уурхай эрхлэх үйл ажиллагааг дахин илэрч болзошгүй Гар аргаар уул уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн асуудал нь байнга эрсдэлд байдаг бөгөөд эдгээр иргэдэд зохистой эрүүл мэндийн үйлчилгээ хүргэхэд бэрхшээлтэй байдаг. Гар аргаар уул уурхай эрхлэгчид нь мөн биеэ үнэлэх явдлыг өөгшүүлэх өндөр эрсдэлтэй байдаг.*
- *Гар аргаар уул уурхай эрхлэгчид нь олборлосон алтаа борлуулахын тулд хуулиас гадуурхи сувагаар зөөвөрлөж худалддаг ба ихэвчлэн Хятад улс Ттөслийн үйл ажиллагаанаас хулгайлагдсан хүдэр, баяжмалыг борлуулах гарц болох эрсдэлтэй юм.*
- *Тэдгээрийн хууль бус үйл ажиллагааны улмаас, гар аргаар уурхай эрхлэгчдийн суурин нь үргэлж аюулгүй байдлын эрсдэл дагуулж, энэ нь уугуул орон нутгийн иргэдэд нөлөө үзүүлэх магадлалтай.*
- *Гар аргаар уурхай эрхлэгчид байснаар угаас хязгаарлагдмал түвшинд буй орон нутгийн үйлчилгээ болон нөөцөд нэмэлт ачаалал учирна.*

Гар аргаар уул уурхай эрхлэх үйл ажиллагаа нь хэд хэдэн бусад сөрөг нөлөөллийг дагуулах бөгөөд ялангуяа газар, усны нөөц бохирдох, эрүүл мэнд аюулгүй байдлын асуудлууд босч ирэх, нөөцийн төлөөх өрсөлдөөн болон тэмцэл гэх мэт орно. Хамгийн анхаарал хандуулах гол асуудал бол бичил уурхайчид алтаа угаах, ялгах явцдаа мөнгөн ус ашиглаж үүнтэй холбоотой үүсэх эрүүл мэндийн асуудал юм. Хяналтгүй гар аргаар уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа болон албан бус гэр суурингууд үүсэх процесстэй холбоотой бусад асуудлуудад архидан согтууруулах бодис их хэмжээгээр хэрэглэх, хууль бус худалдаа, мөрийтэй тоглоом зэрэг орно.

Нөлөөлөл бууруулах арга хэмжээ

Оюу Толгой төслийн олон нийттэй харьцахболон нийгмийн гүйцэтгэлийн хэлтсээс хараа хяналтгүй гар аргаар уурхай эрхлэх үйл ажиллагаа дэлгэрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөсөн нөлөөлөл бууруулах, хяналт мониторинг хийх үйл ажиллагаанд дараах зүйлс багтана:

- *Бичил уурхайн талаар төслийн тодорхой байр суурьтай болох;*
- *Сум болон аймгийн удирдлагатай хамтран төслийн нөлөөллийн бүс дотор илрэх аливаа бичил уул уурхайтай холбоотой үйл ажиллагааг хянах,*
- *Хэрэв бичил уул уурхай эрхлэлт төслийн нөлөөллийн бүс дотор их хэмжээний хүнийг хамарч, асуудал болж хувирах тохиолдолд ТББ-ын уул уурхайн талаарх хөтөлбөрт*

⁴⁷ Оюу Толгой: Хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ. Барклей & Ассоциатэс. 2007 оны 10 сар

⁴⁸ Гар аргаар уул уурхай эрхлэгчид нь Монгол улсын уул уурхайн үйл ажиллагааг зохицуулдаг одоо үйлчилж буй хууль эрх зүйн зохицуулалтаас гадна үйл ажиллагаа явуулдаг. Монгол улсын Засгийн газар энэхүү салбарыг зохицуулахын тулд хэд хэдэн алхам хийсэн бөгөөд үүний нэг нь 2005 онд улсын их хурлаар хэлэлцэгдэж батлагдаж чадалгүй орхигдсон Бичил Уурхайн Тухай Хууль юм. Ихэнх гар аргаар олборлосон алтыг гэр дэлгүүрүүд болон Хятад болон Өмнөд Солонгос улс руу хууль бусаар эксдортлох наймаачдад худалдагдаж буй тул Засгийн газар их хэмжээний татварын орлогоо алдаж байна. Эх сурвалж: Дэлхийн банк, (2006) Монгол: *Уурхайн салбар дахь нийгэм, байгаль орчны нөлөөллийн тойм, Дэлхийн банкны групп, Вашингтон*, Д.К.

дэмжлэг үзүүлж бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанаас гарах эрүүл мэнд болон байгаль орчны эрсдлүүдийг бууруулах тал дээрх зохион байгуулалттай хамтран ажиллах.

Нөлөөллийн эрчим

Бичил уул уурхайтай холбоотой Оюу Толгой төслийн шууд нөлөөллийн бүст учруулах аливаа нөлөөлөл нь **бага хэмжээний сөрөг** байх ба **орон нутгийн шинжтэй**, тохиолдох **магадлалтай**, үргэлжлэх хугацааны хувьд **дунд хугацаанд** байх төлөвтэй байна. Дээр дурдсан цогц хэмжээний нөлөөлөл бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлснээр иргэдэд үзүүлэх нийт нөлөөллийг үлдэгдэл нөлөөллийн ач холбогдлыг **үл мэдэгдэх** хүртэл бууруулах боломж олгоно.

8.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ХУРААНГУЙ

Төслөөс үүдэлтэй хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас үүсэх гол нөлөөллийг дараах байдлаар тусгав. Үүнд:

- *Даланзадгадад хүн амын тоо өсч (Өмнөговь аймгийн төв), өмнө Говь бүсийн хэмжээнд одоо идэвхитэй ажиллаж буй уул уурхайн төвүүд рүү шилжин ирэх хүн амын хөдөлгөөн эрчимжиж, улмаар бүсийн дэд бүтцэд ачаалал үүснэ.*
- *Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс, ялангуяа Ханбогд суманд хүн ам өсч орон нутгийн дэд бүтэц, байгууламжид их хэмжээний ачаалал учруулах ба холбогдох үйлчилгээний эрэлт нэмэгдэнэ. Эдгээр үйлчилгээнд:*
- *Одоогийн эрчим хүч, цахилгаан хангамжийн дэд бүтцэд очих ачаалал нэмэгдэх;*
- *Усан хангамжийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж хөдөө нутагт усан хангамж тасалдаж болзошгүй;*
- *Хангалтгүй, хөгжөөгүй ариун цэвэр болон бохирын системээс үүдэлтэй асуудал хурцдана;*
- *Хаягдал цуглуулах, хаях байгууламж байхгүй байдлын улмаас хатуу хог хаягдлын хуримтлал ихсэнэ ;*
- *Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадал хэтэрнэ;*
- *Бүх шатны сургуулиудад боловсролын үйлчилгээ хүргэх, сургалтын байгууламжаар хангах явдалд ачаалал үүсэх зэрэг багтана.*
- *Төсөлтэй холбоотой ажил горилон шилжин ирэх эдийн засгийн сэдэлтэй хүн амын хөдөлгөөн нэмэгдэж орон сууцны хэрэгцээ өсөх*
- *Хууль бус гар аргаар уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа дахин сэргэх.*

Нөлөөлөл бууруулах зохих арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэх тохиолдолд, бүс нутгийн болон төслийн нөлөөллийн бүс доторх хүн амын шилжих хөдөлгөөний улмаас үүсэх аливаа сөрөг нөлөөллүүдийг **бага хэмжээнд** хүртэл бууруулах боломжтой.

Хүснэгт 8.5-д нөлөөлийг хариу авах арга хэмжээний хамтаар дүгнэсэн ба хүн амын шилжин ирэх явдлын (нөлөөлөл бууруулах арга хэмжээ авсны дараа) үлдэгдэл нөлөөллийн ач холбогдлыг үнэлсэн.

Хүснэгт 8.5: Нөлөөллийн дүгнэлт: Хүн амын шилжилт хөдөлгөөн

| Нөлөөлөл | (1) Нөлөөлөлд өртөгч | (2) Үе шат | (3) Нөлөөллийн ангилал | (4) Ач холбогдол | Шийдэл, Сайжруулах буюу Нөлөөлөл бууруулах арга хэмжээ | Менежментийн төлөвлөгөө, Бодлого болон дүрэм журам | Үлдэгдэл нөлөөллийн эрчим |
|---|--|------------------------------|--|---------------------|--|---|-----------------------------|
| Даланзадгадын хүн ам өсөх, бүс хоорондын хүн амын хөдөлгөөн, бүс нутгийн дэд бүтэцэд үзүүлэх нэмэлт ачаалал | Бүсийн (Өмнөговь аймаг) иргэд, аймгийн төвийн болон орон нутгийн иргэд | Барилгын ба Үйлдвэрлэл | Үргэлжлэх хугацаа Дунд Хамрах Хүрээ Хязгаарлагдмал Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Оюу Толгойн Бүсийн Төлөвлөлт болон Дэд бүтэц хариуцсан хэлтсийн байгуулалт болон үйл ажиллагаа. Өмнөговь бүсийн хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох, тухайлбал хүн ам шилжих хөдөлгөөнийг зохицуулах, бүс нутгийн төлөвлөлт ба хөгжилд хамтран ажиллах. Бүсийн дэд бүтэц болон нэн тэргүүнд шаардлагатай байгаа хөгжлийн хэрэгцээг шийдвэрлэхийн тулд орон нутгийн удирдлага, засгийн газартай хамтран ажиллах. Бүсийн дэд бүтэц болон хөгжилд зориулж шууд хөрөнгө оруулах болон хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмжих | <ul style="list-style-type: none"> Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээний Хэсэг 4-д заасан шаардлага (Бүсийн хөгжил) Оюу Толгойн бүсийн хөгжлийн хөтөлбөр Оюу Толгойн бүсийн хөгжил ба орон сууцжуулах явдлыг дэмжихэд зориулсан мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |
| Эдийн засгийн шалтгаанаар шилжин ирэгсэд болон орон сууцны өсөн нэмэгдэж буй хэрэгцээ | Орон нутгийн (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэлийн | Үргэлжлэх хугацаа Дунд Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Орон нутгийн болон бүсээс ажилтан элсүүлэх явдлыг дэмжих Уурхайн талбайд сонгон шалгаруулалтгүйгээр шууд ирсэн хүнийг ажилд элсүүлэхгүй байх Зориулалтын ажилтан элсүүлэх төвүүд ашиглаж, албан бус ажилтан элсүүлэх явдлыг хориглох Ажилтан элсүүлэх журмыг, тухайн ажлын шаардлагын дэлгэрэнгүй тайлбарын хамтаар өргөн хүрээнд сурталчилах Барилгын ажилчдад зориулан кемп бариснаар орон нутгийн орон сууцны эрэлтэнд үзүүлэх ачааллыг багасгах Үйлдвэрлэлийн шатны ажилчдад зориулан Ханбогд төвтэй орон сууц барих Орон нутгийн бус төслийн ажилчдын хэрхэн зорчих асуудалд зохицуулалт хийх (АИАБ / ОИОБ) | <ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын гэрээний шаардлагын дагуу орон нутгийн \Монгол улсын иргэнийг ажлын байраар хангах тухай үүрэг Оюу Толгойн ажилтан элсүүлэх бодлого болон дүрэм журам Оюу Толгой кемпийн бодлого болон харилцааны ёс зүйн дүрэм Ханбогд төвтэй орон нутгийн цогц загвар Гомдол шийдвэрлэх журам Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |
| Эрчим хүч, цахилгаан | Орон нутгийн | Барилгын болон | Үргэлжлэх хугацаа | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Төсөл цахилгаан эрчим хүчний хангамжаа (ажилчдын кемп) бие даан шийдвэрлэхийн | <ul style="list-style-type: none"> Оюу Толгойн бүс нутгийн хөгжлийн хөтөлбөр | Бага хэмжээний |

| Нөлөөлөл | (1) Нөлөөлөлд өртөгч | (2) Үе шат | (3) Нөлөөллийн ангилал | (4) Ач холбогдол | Шийдэл, Сайжруулах буюу Нөлөөлөл бууруулах арга хэмжээ | Менежментийн төлөвлөгөө, Бодлого болон дүрэм журам | Үлдэгдэл нөлөөллийн эрчим |
|--|---|-------------------------------|---|---------------------|---|--|---------------------------------|
| хангамжийн дэд бүтцэд учруулах ачаалал | иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | үйлдвэрлэл ийн | Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | | <ul style="list-style-type: none"> тулд уурхай дээрх дизель хөдөлгүүртэй цахилгаан үүсгүүрүүд хэрэглэх Орон нутгийн цахилгаан үүсгүүр болон түгээлтийн системийг шинэчилж сайжруулахад туслалцаа үзүүлэх. Ханбогд суманд 35 кВ цахилгаан дамжуулах шугамыг барих ажилд санхүүжилт өгөх Ханбогд суманд АХБ-тай хамтран дулааны системийг засаж сайжруулах төсөл дээр ажиллах | <ul style="list-style-type: none"> Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө | сөрөг |
| Усан хангамжийн хэрэгцээ өсөх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэл ийн | Үргэлжлэх хугацаа Дунд Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Малчдын зарим худаг дээр усны чанар болон түвшинд хяналт шинжилгээ хийх, аливаа асуудал гарсан тохиолдолд түргэн шуурхай арга хэмжээ авах Өөр усны эх үүсвэр тогтоохын тулд гүний усны хайгуул хийж, уст давхрагын өрөмдлөг хийх/ дээж авах Боломжит гүний усны нөөцийн гарцыг үнэлэх Ханбогд сумыг усаар хангах төслийг нарийвчлан боловсруулах | <ul style="list-style-type: none"> Оролцоонд түшиглэсэн усны хяналт шинжилгээний хөтөлбөр Усны цооног өрөмдөх хөтөлбөр Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |
| Цэвэрлэх байгууламжид үзүүлэх ачаалал нэмэгдэх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэл ийн | Үргэлжлэл Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Уурхай дээр бие даасан бохир ус цэвэрлэх байгууламж ажиллуулах Зохион байгуулалттай бохир ус цэвэрлэх систем болон боловсржжлах ажилд дэмжлэг үзүүлэх Төслийн барилгын түр кемпүүдэд ашиглагдаж байсан цементийн реакторын бохир ус цэвэрлэх төхөөрөмжүүдийг кемп татан буугдсаны дараа Ханбогд суманд шилжүүлэх | <ul style="list-style-type: none"> Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |
| Хатуу хог хаягдал цуглуулах, хаях ажиллагаа ачааллаас хэтрэх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэл ийн | Үргэлжлэх хугацаа Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Төслийн барилгын ажлын үед дунд хугацааны хаягдлын менежментийн байгууламжийг ажиллуулах Төслийн үйлдвэрлэлийн шатанд зориулж зориулалтын хаягдлын менежментийн төвийг ашиглах Төслийн барилгын болон үйлдвэрлэлийн шатанд хаягдлыг дахин боловсруулалт | <ul style="list-style-type: none"> Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |

| Нөлөөлөл | (1) Нөлөөлөлд өртөгч | (2) Үе шат | (3) Нөлөөллийн ангилал | (4) Ач холбогдол | Шийдэл, Сайжруулах буюу Нөлөөлөл бууруулах арга хэмжээ | Менежментийн төлөвлөгөө, Бодлого болон дүрэм журам | Үлдэгдэл нөлөөллийн эрчим |
|--|--|------------------------------|---|---------------------|---|--|---------------------------------|
| | | | | | <p>хэрэглэх</p> <ul style="list-style-type: none"> Ханбогд сумын төвд хаягдал цуглуулах систем болон хог хаягдал дарж булж устгах цэгүүдийг байгуулахад Засгийн газар болон АХБ-тай хамтран дэмжлэг үзүүлнэ. | | |
| Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадалд ачаалал өгөх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэлийн | Үргэлжлэх хугацаа Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Эмч нарын тэтгэлэгт хөтөлбөр Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төв байгуулах Ханбогд суманд шүдний эмнэлэг нээх Жавхлант багт гэмтлийн төв нээх Төслийн нөлөөллийн бүс дэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээний хүчин чадал болон хүртээмжийг үнэлэх Өвчний тохиолдлуудад хяналт шинжилгээ | <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн хөтөлбөр Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |
| Боловсролын үйлчилгээ болон байгууламжийн ачаалал нэмэгдэх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэлийн | Үргэлжлэх хугацаа Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутагт Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Мэргэжил дадлагын сургалт явуулах, дадлагажуулах хөтөлбөр явуулах мөн бакалаврын дараах сургалтын оюутнуудад тэтгэлэг өгөх Ханбогд суманд Засгийн газартай хамтран сургуулийн өргөтгөл хийх ажлыг санхүүжүүлэх Ханбогд суманд цэцэрлэгийн өргөтгөл барих Налайх болон Даланзадгадад хотод техник мэргэжлийн 2 сургалтын коллежийг шинээр барих мөн одоо ажиллаж буй 5 техник мэргэжлийн коллежийг засварлах | <ul style="list-style-type: none"> Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан сургалтын тухай шаардлагууд Оюу Толгойн таван жилийн сургалтын стратеги болон төлөвлөгөө Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |

| Нөлөөлөл | (1) Нөлөөлөлд өртөгч | (2) Үе шат | (3) Нөлөөллийн ангилал | (4) Ач холбогдол | Шийдэл, Сайжруулах буюу Нөлөөлөл бууруулах арга хэмжээ | Менежментийн төлөвлөгөө, Бодлого болон дүрэм журам | Үлдэгдэл нөлөөллийн эрчим |
|---|--|------------------------------|--|---------------------|--|---|-----------------------------|
| Хууль бус гар аргаар уул уурхай эрхлэгчид дахин гарч ирэх | Орон нутгийн иргэд (төслийн нөлөөллийн бүс) болон Ханбогд сумын иргэд | Барилгын болон үйлдвэрлэлийн | Үргэлжлэх хугацаа Дунд хугацааны Хамрах Хүрээ Орон нутаг Магадлал Тодорхой | Дунд зэрэг сөрөг | <ul style="list-style-type: none"> Оюу Толгой орчмын талбайн бичил уурхайн үйл ажиллагааг илүү нарийвчлан судалж, тэдний байршил, оролцооны түвшин болон холбогдох байгаль орчин болон эрүүл мэндийн эрсдлийг тодорхойлох Төслийн санхүүжүүлж буй Халдварт өвчин ДОХ-с урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зорилтот бүлэгт гар аргаар уул уурхай эрхлэгчдийг хамруулах | <ul style="list-style-type: none"> Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын төлөвлөгөө | Бага хэмжээний сөрөг |

Тэмдэглэгээ:

(1) Нөлөөлөлд өртөгч: Нөлөөлөлд өртсөн эсвэл бусад сонирхогч талууд

(2) Төслийн үе шат: Барилгын, үйлдвэрлэлийн, үйл ажиллагааны татан буулгалт, уурхайн хаалт

(3) Нөлөөллийн ангилал:

Үргэлжлэх хугацаа: Богино хугацааны, дунд хугацааны, урт хугацааны

Хамрах Хүрээ: зөвхөн орон нутгийн шинжтэй; орон нутгийн; хязгаарлагдмал; өргөн хүрээнд тархсан

Магадлал: Магадлалгүй, магадлал багатай, магадлалтай, тодорхой

(4) Болзошгүй эрчим: Их хэмжээний сөрөг, дунд зэрэг сөрөг, Бага хэмжээний сөрөг, нөлөөгүй, эерэг

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.